



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.01.09, ЛХАГВА ~ №005 (1057)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Хотын бүх сургуулийг автобустай болгоход 100 жил шаардлагатай юу

Нэг хичээлийн жилд төрийн өмчийн гурван сургуульд л автобус олгож байна. >4

БОЙКОТОО ЗОГСОЖ АЖЛАА ХИЙЦГЭЭ

Халаасанд нь оршдог хууль цаазын байгууллагатайгаа нийлээд хамгаалсан. >6

Гаднынхаас илүү дотоодын хөрөнгө оруулалтад найдах хэрэгтэй

Нэг өрх дунджаар 560 мянган төгрөгийн зээлтэй. >11

ZGM DAILY

FULL ENGLISH PAGE INSIDE

>7

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Элчин сайд Б.Ганболд НҮБ-ын зүүн зүгд азийн салбар төвийн захирал болжээ. Ерөнхийлөгч Х.Баттулга Австрийн Элчин сайдыг Найрамдал медалиар шагнав. С.Чинзориг: Цалин нэмэх асуудлыг амжалттай долоо хоногт ЗГ-ын хуралдаанд оруулна. Прокуророос гурван гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг УИХ-д өргөн барьжээ.

ЭДИЙН ЗАСАГ

Гадаад худалдааны бараа эргэлт өнгөрсөн онд 22.3% өсөж, \$12.8 тэрбумд хүрсэн байна. Улсын төсвийн хөрөнгөөр геологи хайгуулын 41 төсөл хэрэгжиж байна. Гашуунсухайт – Ганцмод боомтоор 2018 онд 18.2 сая тонн нүүрс экспортолжээ. Топ 20 индекс 0.24 хувиар буурч, 218822.04 нэгжид хүрлээ.



НИЙГЭМ

АНУ-ын Хавайд 13 настай Монгол хүү усанд осолдож нас баржээ. ОБЕГ-аас сүм, хийд, шашны байгууллагуудад шалгалт хийж байна. Б.Бүрэнбаатар: Сар шинээр цагдаагийн байгууллага өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллана. Монгол Улс, БНХАУ-ын хүмүүнлэгийн солилцооны механизмын уулзалт Бээжинд болно.

ДЭЛХИЙ

Бээжин дээд тушаалтнаа ирүүлсэн тул хэлэлцэн тохиролцох байх гэж Цагаан ордон мэдэгдэв. Хятадын компаниуд 2018 онд АНУ-ын 12589 патентыг шилжүүлэн авсан байна. Nissan-ы захирал байсан Карлос Гон анх удаа олны өмнө үг хэлэхдээ “би буруугүй” хэмээв. Японы бизнесмен Ю.Маезава хамгийн олон retweet, like авсан жиргээний эзэн боллоо.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
2019.01.09



-11° -22°

ҮҮЛ БАГАСНА

ЦАГ АГААРЫН ДЭГЖЭЭНГҮЙ МЭДЭЭЛИЙГ
8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

ЭНЭ УЛСАД ЧИНЬ ТОМУУГИЙН ТАХАЛ НҮҮРЛЭЧИХЭЭД БАЙГААГ МЭДЭЖ БАЙГАА ХҮН БАЙНА УУ



Гурван жилийн хугацаанд 30 хүний амийг авч одсон цар тахал буюу гахайн ханиад Монголд жирийн томуу шиг “нутагшжээ”. Б.Хасуй / ЗГМ ©
Он гарсаар нэг долоо хоногийн хугацаанд томуугийн шинж тэмдэгтэй 4136 өвчтөн амбулаториор үйлчлүүлжээ. ▶ 5

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Утаа түгжрэл аль нь ч буурахгүй

Г.Байгал
@baigalZGM

Нийслэлийн иргэн та Улаанбаатарт оршин суугаадаа сэтгэл хангалуун байна уу. Даажигнаж байгаа юм биш шүү. Гэрээс гарах төдий л өтгөн утаа нь нүд хорсон, хоолой боож, ханиаданд дарлуулж, халуурч бүлээрсэн нялх үрс хувь, хувьсгалын эмнэлгүүдийг дүүргэж байна. Улаанбаатарт амьдрах арга алга хэмээн бидний олонх нь дэмий бухимдаж, дотроо бачимдаж буй нь нууц биш. Гэхдээ уурыг нь барж, эрүүл мэндийг хохироож буй энэ олон асуудлыг шийдэх хотын төсвөө сөхөж үздэг нь бидний дунд хэр олон бол. Үнэндээ иргэд нийслэлийн төсвийг тоодоггүй. Сөхөж харах нь бүү хэл сонирхож сонсох нь ховор.

Нийслэлийн 1.3 сая иргэн жилд дунджаар 600 тэрбум төгрөгийг хотын төсөвт төвлөрүүлдэг. Энэ бол ус, ой зэрэг улсын аль нэг нөөц ашигласны төлбөрийг тооцоогүй зөвхөн иргэдийн халааснаас албан татвар хэлбэрээр хотын төсөвт очдог мөнгөн дүн. Нийслэлчүүд ийнхүү хотын төсвийн талаас илүүг бүрдүүлдэг атлаа төлсөн татварыг нь юунд зарцуулдгийг ч үл ойлгоно. Уг нь жил бүрийн 12 дугаар сард баталдаг хотын төсөв Нийслэлийн иргэдийн төлөөлөгчид гэх хэсэг хүний хэлэлцдэг хэдэн хуудас цаас биш Улаанбаатараар овоглосон иргэн бүрт хамаатай бодлогын баримт бичиг.

Нийслэлийн энэ оны хөгжлийг зурагласан бодлогын баримт бичгийг өнгөрсөн оны сүүлчээр Нийслэлийн ИТХ-аар баталж, дагаж мөрдөх хууль журам болголоо.

▶ 3

ЭДИЙН ЗАСАГ

Манай эрх баригчид татвар нэмэхдээ шаламгай, багасгахдаа хойрго

Дарга нар татвар нэмэхдээ татварын шинэчлэлийг олж хараагүй

3.Цэлмэг
@tselmegZGM

Өнгөрсөн оны 11 дүгээр сард татварын орлого 2.2 их наяд төгрөгөөр давж биелэхэд иргэдийн цуглуулсан НӨАТ-ын 300 сая орчим баримт тун чухал үүрэг гүйцэтгэжээ. Үүний үр дүнд өнгөрсөн онд НӨАТ-ын буцаан олголт 125 тэрбум

төгрөгт хүрсэн нь 2017 оныхоос бараг хоёр дахин өндөр дүн. Буцаан олголт иргэдийн дансанд шилжсэнээр тэр хэмжээний мөнгө худалдаа, үйлчилгээний салбарыг тэтгэнэ гэсэн үг. Энэ бол дэлгүүр, үйлчилгээний төв, албан байгууллага бүрт байгаа кассын хар машин буюу НӨАТ-ын баримт хэвлэгчийн тоо өнгөрсөн гурван жилд 90 мянгад хүрсний үр дүн. Түүнээс биш 2017 онд ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдахдаа долоон төрлийн татвар хураамжийг нэмсний үр дүн биш аж. Яагаад гэвэл тэр үед ч, одоо ч татвар нэмэх суурь орчин бүрдээгүй. Өөрөөр хэлбэл, татварын хувь хэмжээг

нэмлээ ч шийдвэр гаргагчдын анх зорьсон шиг төсвийн орлого нэмэгдэхгүй. Хэрэв энэ янзаараа байсаар байвал магадгүй таван жилийн дараа ч татвар нэмлээ гээд гарах үр дүн нь сөрөг байх бололтой. Татвар зөвхөн төсвийн орлого бүрдүүлэгч биш. Харин эдийн засгийг зохицуулдаг механизм. Гэтэл манай эрх баригчид татвар нэмэхдээ шаламгай, бууруулахдаа хойрго. Уг нь татвар уян хатан, шударга, оновчтой байх тусам эдийн засгийн бүтцийг сайжруулж, эс бөгөөс далд эдийн засаг бий болгодог.

▶ 12

ДЭЛХИЙ

Хятадаас үүдэн Goldman Sachs үнийн таамгаа бууруулав

Хятадын эдийн засаг “мэдэгдэм саарсан”-тай уялдан Goldman Sachs Group металлын богино хугацааны үнийн таамгаа бууруулж өөрчиллөө. Мөн эх газрын Хятадын бодлого тодорхойлогчид өнгөрсөн оны сүүлийн хагасаас зах зээлээ дэмжиж, зэс, хөнгөн цагааны үнийг өөд татахаар чармайж буйтай уялдан тус банк, санхүүгийн групп цаашдын хэтийн төлөвтөө тэнцвэр бариулахаар хичээж байна.

Goldman Sachs нь 2019 онд түүхий эд материалын үнэ, нийлүүлэлт өсөх баавгайн байр суурь баримталж иржээ.

Урьд нь тус групп гурван сарын дотор нийлүүлэх зэсийн нэг тонныг 6500, зургаан сард нийлүүлэх зэсийн нэг тонныг 7000 ам.доллараар тооцоолж байсан бол эдүгээ тус бүр 6100, 6400 болгон буурууллаа.

Харин 12 сарын дотор нийлүүлэх зэсийн нэг тонныг 7000 ам.доллараар тооцож байна. БНХАУ-д “эдийн засгийн олон салбарт үүссэн сулралыг зогсоож, өсөлт үүсгэх бодлого чухал болсон”-ыг Хуэй Шань зэрэг шинжээчдээс нэгдүгээр сарын дөрвөнд гаргасан мэдэгдэлд анхааруулжээ.

▶ 10

АЛТ

1283.43
0.45%

ЗЭС

5923
0.08%

10-ЧИНГИС БОНД

94.26
0.00%

ХУРАЛДАЙ БОНД

107.52
0.1%

ГЭРЭГЭ БОНД

95.63
0.16%

АМ.ДОЛЛАР

2663.98

ЮАНЬ

388.33

РУБЛЬ

39.62

Улс төр

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

Бүлэг хуралдвал УИХ гацаанаас гарах боломж байна

Сэргээгдэх эрчим хүчний хуулиар замбараагүй олгосон зөвшөөрлийг цэгцлэнэ

П.Батбөх
ЗГМ

Эдийн засгийн байнгын хорооны дарга Д.Дамба-Очиртой цаг үеийн зарим асуудал болон сэргээгдэх эрчим хүчний хуульд орж буй өөрчлөлтийн талаар ярилцлаа.



-Таны даргалдаг байнгын хорооны хурал хэд дэх удаагаа хойшлоод байна вэ?

-Долоо дахь удаагаа хойшилло. Ирц бүрдээгүй шалтгаанаар хуралдаж чадахгүй байна.

-Нэн яаралтай хэлэлцэх асуудал хэр хуримтлагдсан бэ?

-Зам тээврийн сайд Я.Содбаатарыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, Ашигт малтмал, Газрын тос, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг нэн яаралтай хэлэлцэх шаардлагатай. Мөн Беларусь улстай хийж байгаа хэлэлцээрийг яаралтай хэлэлцэж батлах шаардлага байна.

-Таны хувийн компани Бе-



Б.Хасуй / ЗГМ

Татварын багц хуулийг батлахгүй хойшлогдож байгаа нь бизнес эрхлэгчдэд муугаар нөлөөлж байна

ларусь улстай бизнесийн том гэрээ байгуулсан учраас тус улсад Элчин сайдын яам байгуулах асуудлыг лоббилож байгаа гэх юм. Үүнд тайлбар өгнө үү?

-Миний хамаарал бүхий компани Беларусь улстай ямар ч харилцаа байхгүй гэдгийг хариуцлагатай хэлье. Тиймээс лобби хийх тухай зүйл огт байхгүй. Хоёр орны хооронд хийх гэрээг УИХ-аар соёрхон батлах тухай л хэлэлцэж байгаа.

-Та байнгын хорооны гишүүдийн ирцийг бүрдүүлэх талаар ямар ажил хийж байна вэ?

-Гишүүд байнгын хорооны хурлын ирцийг бүрдүүлэхгүй байгаа нь бүлгийн хуралтай холбоотой. Манай намын бүлэг яаралтай хуралдах зар тараасан байгаа. Бүлэг хуралдчихвал байнгын хороодын хурал хэвийн үргэлжлэх боломж бүрдэнэ гэж харж байна.

-Эдийн засгийн байнгын хороо, цаашлаад УИХ хуралдаж чадахгүй байгаагаас манай улсын эдийн засагт сөрөг үр дагавар гарч байгаа юу?

-Шийдэх ёстой зохицуулалт, хуулийн өөрчлөлтийг хийгээд явж байгаа. Одоогоор асуудал үүсгэж, эдийн засагт ноцтой нөлөөлсөн зүйл алга. Улс төрийн нөхцөл байдал шийдэгдчихвэл

Эдийн засгийн байнгын хороо хуралдаад шаардлагатай хууль, тогтоолын төслүүдийг шийдвэрлээд л явчихна.

-Татварын багц хуулийг УИХ-д өргөн барьсан ч 2019 оноос өмнө баталж чадсангүй. Энэ нь бизнес эрхлэгчдэд муугаар нөлөөлж байгаа юм биш үү?

-Тийм. Татварын багц хуулийг УИХ яаралтай батлах нь зөв. УИХ-ын гацаанаас болж төлөвлөж байсан хугацаанаас хоцорч, энэ нь бизнес эрхлэгчдэд тодорхой хэмжээнд муугаар нөлөөлж байхыг үгүйсгэхгүй. УИХ гацаанаас гарчих юм бол үүнийг яаралтай хэлэлцээд баталчих байх. Гол асуудал УИХ-ыг гацаанаас гаргахад л байна.

-Таны санаачилсан Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг оноос өмнө баталж амжсангүй. Тус хуульд ямар зохицуулалт орж байгаа вэ?

-Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр замбараагүй олгосон зөвшөөрлийг цэгцлэх үүднээс тус хуулийг өргөн барьсан. Мөн хуулиар олон улсад мөрдөгддөг загвар стандарт, хэм хэмжээг Монголын нөхцөлд тохируулж тодорхой болгож байгаа. Монгол Улсын хэмжээнд 200 гаруй зөвшөөрөл олгосноос болж сэргээгдэх эрчим хүчний

замбараагүй байдал бий болсон. Энд тэндгүй сэргээгдэх эрчим хүчний байгууламж, станц барихаар төлөвлөсөн байгаа. Хэдийгээр Монгол орон нар, салхины эрчим хүч үйлдвэрлэх баялаг нөөц боломжтой ч хэрэглээнээс хэтэрсэн эрчим хүч үйлдвэрлэх нь ашиггүй. Өнөөдөр улсын хэмжээнд 800 мегаватт эрчим хүч л хэрэглэж байгаа шүү дээ. 2018 онд сэргээгдэх эрчим хүчээр 100 мегаваттыг гаргасан байна лээ.

Хэрвээ энэ хуулийг баталж, зөвшөөрлийг цэгцлэхгүй бол 2019 онд маш их эрчим хүч нийлүүлэгдэхээр байгаа.

-Сэргээгдэх эрчим хүчний ашиглаж л байвал сайн биз дээ?

-Тийм биш юм аа. Өнөөдөр сэргээгдэх эрчим хүчийг нүүрсний эрчим хүчнээс гурав дахин өндөр өртгөөр үйлдвэрлэж байгаа учраас их хэмжээгээр нийлүүлээд эхлэхээр айл өрх, албан байгууллагын сахилгааны үнэ нэмэгдэхэд хүрэх юм. Тиймээс юуны түрүүнд хуулиар зохицуулалт хийх шаардлагатай байна. Ингэхдээ тендер зарлаж, санхүүгийн чадвартай бага өртгөөр эрчим хүч үйлдвэрлэх, станц барих туршлагатай компанийг шалгаруулах, нэг киловаттыг 12 центээс хэтрүүлэхгүй

үнээр нийлүүлдэг байхаар зохицуулж байгаа. Өнөөдрийн байдлаар манай улс сэргээгдэх эрчим хүчний үнийн хувьд дэлхийд хамгийн өндөр. Бусад орнууд 4-8 центээр сэргээгдэх эрчим хүч авдаг бол манайд 16-18 байгаа. Үүнийг л зохицуулахаар Сэргээгдэх эрчим хүчний хуулийг өргөн барьсан. Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцээд дэмжсэн, УИХ-ын чуулганаар батлах үлдээд байна.

-Сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлт илүү гарснаар үнэ нэмэгдэхээс өөр эрсдэл байгаа юу? Оюутолгой зэрэг эрчим хүчний хэрэглээ өндөр үйлдвэр уурхайд "шахаж" болохгүй юу?

-Аль ч улсад сэргээгдэх эрчим хүчний хүчин чадал нийт ашиглаж байгаа эрчим хүчний 30 хувиас хэтэрдэггүй. Түүнээс хэтрүүлбэл зохистой харьцаа алдагдана. Яахав манай эрчим хүчний хэрэглээ 2-3 дахин нэмэгдээд, том станцууд ашигдалтад орвол сэргээгдэх эрчим хүчний их хэмжээгээр гаргаж болно. Гол нь нүүрсээр үйлдвэрлэж байгаа цахилгаан, эрчим хүчний үнэ найман цент орчим байхад сэргээгдэх эрчим хүчний 18 байна шүү дээ. Ийм үнээр эрчим хүчээ хангана гэвэл цахилгааны үнэ огцом нэмэгдэх эрсдэлтэй. [ЗГМ]

ЗГМ: ТОВЧХОН

» ЕРӨНХИЙЛӨГЧ

Төрийн тэргүүн зарлиг гаргаж Австрали улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жон Ховард Лангтрийг хоёр орны найрсаг харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Найрамдал медалиар шагнажээ. Жон Лангтри нь Австрали улсаас манай оронд томилогдон ирсэн анхны Элчин сайд бөгөөд удахгүй нутаг буцах юм.

» ПАРЛАМЕНТ

УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэг Ерөнхий сайд У.Хурэлсүхэд хандсан асуулгынхаа хариуг авчээ. Тус хариунд Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарын өнөөгийн байдлын талаар дэлгэрэнгүй танилцуулга болон үүрэн холбооны компаниудын үнэ тарифын өөрчлөлт, төрийн мэдээллийн санд халдсан кибер халдлагын тухай мэдээлэл багтжээ.

» ЦЭЦ

ҮХЦ ирэх долоо хоногт Их суудлын хуралдаан хийхээр төвлөжээ. Тус хурлаар Сонгуулийн тухай хуулийн 60.5 дахь заалтад "Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлэггүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй" гэж заасан нь Үндсэн хууль зөрчсөн эсхийг хянан хэлэлцэх юм.

» ЗАСГИЙН ГАЗАР

Засгийн газраас шатахууны үнийг 350 төгрөгөөр бууруулах боломжтой гэж тооцож байгаа бөгөөд өнөөдөр Засгийн газрын хуралдаанаар импортлогч компаниудын байр суурийг хэлэлцэн шийдвэр гаргах аж. Өнгөрсөн даваа гарагт ЗГХЭГ-ын дарга АМГТХЭГ-ын удирдлагуудад нефть импортлогч компаниудын удирдлагатай зөвшилцөхийг үүрэг болгосон юм.

» ТОО

48

Ерөнхийлөгч Х.Баттулга сонгогдсоноосоо хойших нэг жилийн хугацаанд манай улсад эх орноо төлөөлөн суугаа 48 орны Элчин сайдыг хүлээн авч уулзжээ. Мөн Монгол Улсад айлчилсан болон ажилласан гадаадын байгууллагын төлөөлөлтэй 52 удаагийн уулзалт хийжээ

ПАРЛАМЕНТ

УИХ-ын зарим гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх санал хүргүүлжээ

Улсын Ерөнхий прокуророос УИХ-ын дөрвөн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг УИХ-ын дарга М.Энхболдод хүргүүлсэн байна. Прокуророос УИХ-ын гишүүн Б.Ундармаа, Л.Энхболд,

Г.Солтан нарыг ЖДҮХС-гаас хамаарал бүхий этгээдээрээ дамжуулж зээл авахдаа албан тушаал, эрх мэдлээ ашигласан байж болзошгүй гэж үзсэн бололтой. ЖДҮХС-тай холбоотой хэргийг АТГ

шалгаж байгаа бөгөөд тус байгууллагаас өнгөрсөн сард нэр бүхий гишүүдийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг прокурорт хүргүүлсэн тухайгаа мэдээлж байсан юм. Мөн прокурорын зүгээс УИХ-ын

үйл ажиллагаа хэвийн болсон үед гишүүдийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх бичиг хүргүүлэх тухай ч ярьж байв.

УИХ Ерөнхий прокурорын саналыг 48 цагийн дотор хэлэлцэж, шийдвэр гаргах

хуультай бөгөөд өчигдөр УИХ-ын Халдашгүй байдлын дэд хорооны хуралдааныг зарлан хуралдуулахаар болсон ч гишүүдийн ирц бүрдээгүйгээс хойшлуулсан байна. [ЗГМ]

Ёс зүйн дэд хорооны гишүүдийг өөрчлөхөөр ярилцжээ

Г.Билгүүн
ЗГМ

Парламентын гишүүдийн ёс зүйг хянаж байх үүрэгтэй дэд хороог хуралдуулах тов сар гаруйн өмнө гарсан боловч зургаа дахь удаагаа хойшлоод байна. Тус дэд хороо ЖДҮХС-аас зээл авсан гишүүдийн ёс зүй, 60 тэрбумын хэрэг, гишүүдийн хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлаар хуралдах зорилготой юм. Гишүүдийн ирц хүрэхгүйгээс мухардалд орчихоод байгаа тус хороог хуралдуулахын тулд бүрэлдэхүүнийг солих шаардлагатай гэж УИХ-ын дарга М.Энхболд ярьж байсан удаатай. Харин спикерийн дээрх яриа

“ажил хэрэг” болох чиглэлдээ оржээ. УИХ-ын дарга болон Ёс зүйн дэд хорооны дарга С.Бямбацогтын зүгээс хуралдаа ирэхгүй байгаа зарим гишүүнийг солих саналыг Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцүүлэхээр төлөвлөж байгаа аж. Энэ талаар С.Бямбацогт гишүүн “Хуралдаан зохион байгуулах хэлтэс ирц бүрдүүлэх ажлыг зохион байгуулдаг. Зарим гишүүдийн зүгээс хуралдаанд оролцохгүй гэдгээ ил цагаан хэлж байгаа. Ёс зүйн дэд хорооны гишүүдийг өөрчлөх асуудлыг УИХ-ын дарга ярьж байсан. Энэ асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороогоор шийдүүлнэ” гэсэн юм. Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал өнөөдөр болно. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СӨНИН

1 улирлын нэмэлт захиалга явагдаж байна

ОНЛАЙН ЗАХИАЛГА	ХЭВЛЭМЭЛ ЗАХИАЛГА	ХОСОЛМОЛ ЗАХИАЛГА (Хэвлэмэл + Онлайн)
<p>Улиралд: 50007 (60 дугаар)</p> <p>Хагас жилд: 100007 (125 дугаар)</p> <p>Жилд: 150007 (250 дугаар)</p>	<p>Улиралд: 300007 (60 дугаар)</p> <p>Хагас жилд: 600007 (125 дугаар)</p> <p>Жилд: 1200007 (250 дугаар)</p>	<p>Улиралд: 320007 (60 дугаар)</p> <p>Хагас жилд: 650007 (125 дугаар)</p> <p>Жилд: 1250007 (250 дугаар)</p>

tdbpay
QR кодыг уншуулан гүйлгээний утга хэсэгт и-мэйл хаяг, утасны дугаараа бүртгүүлэн захиалаарай.

QR код ашиглахгүйгээр төлбөр хийх бол:

УЛААНБААТАР ХОТЫН БАНК

2600092954

ТООТ ДАНСАНД МОНГОО ТУШААНА УУ.

[ЗГМ СӨНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээгдэхүүний мэдээллийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор З.Цэлмэг
Утас: 99901526

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1 хороо, Энхтайвны өргөн чөлөө,
“Бло Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР

zgm.mn
ubinfo.mn
Дугаарын удирдагч
Б.Энхжаргал

86 5 8000 429112 001057

Нийтлэлчийн булан

НИЙСЛЭЛИЙН ИРГЭН ТАНД ЗОРИУЛАВ



Утаа түгжрэл аль нь ч буурахгүй

С.Батсайхан / ЗГМ©

Нийслэлийн төсөв нэг их наяд төгрөгт дөхлөө

2019 онд Улаанбаатар хотын төсөв их наяд төгрөгт тулж, урьд өмнө нь сонсогдоогүй их мөнгөн дүн албаныхны гарт төвлөрөхөөр болж байна.

Энэ оны төсвийг сөхвөл нийслэл хотын ерөнхий төрх цагаан цаасан дээр хараар бууж, Улаанбаатарын ирээдүйн өнгийг урьдчилан мэдэж болохоор харагдана. Тухайлбал, энэ онд Улаанбаатарын утаа арилж, уур бардаг түгжрэл буурна гэж горьдилтгүй. Утааны өөдөөс цагаан туг өргөсөн Улаанбаатарын урамгүй тэмцэл ирэх саруудад ч үргэлжилнэ гэж төсвийн тоонууд чимээгүйхэн шивнэж байна. Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн төсвийн санхүүжилт энэ онд дорвитой өсөөгүй. “Утаагүй Улаанбаатар” хөтөлбөрт л гэхэд 3.4 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвт төсөвлөжээ. Хорт утааны эсрэг тэмцлийн хаана нь ч хүрэхгүй энэ мөнгийг дотоод орчны агаарын бохирдлыг бууруулах зэрэг арга ядсан арга хэмжээнд зарцуулах аж.

Агаарын бохирдлыг багасгах найдвар ийн баргар буйтай зэрэгцээд нийслэлчүүдийн шүдний нэг өвчин болох замын түгжрэл дорвитой буурахгүй нь. Автозамын ачааллыг тоймтой буулгах дорвитой төлөвлөгөөг хотын төсвийн 30 гаруй хуудас цааснаас хайгаад олсонгүй. Ийнхүү утаа, түгжрэл зэргээс үр дүн хүлээгээд хэрэггүй нь энэ оны эхнээс харагдаж эхэллээ. Гэхдээ нийслэлчүүдийн усан хангамж нэмэгдэхээр байгаа нь сайшааж болох сайн мэдээ юм. Энэ онд нийслэлийн усан хангамжийг сайжруулж, цэвэрлэх байгууламжийг шинэчлэхэд 4.2 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж байна. Мөн Улаанбаатарыг усгүйн зовлонд унахаас сэргийлэн АНУ-ын Мянганы сорилтын корпорациас усан хангамжийг сайжруулах төсөл хэрэгжүүлэхээр болсон. Уг төслийн барилгын ажил энэ оны сүүлчээс эхэлнэ гэж Америкийн талаас мэдээлж байна.



Нийслэлийн 2019 оны төсөв ©

сонгууль угтсан төсвийн халуурлаас нийслэлийн удирдлагууд ч хазайсангүй, энэ онд төсвийн орлого улам нэмэгдүүлсэн байна.

2019 оны хотын төсвийн орлого 2016 оныхтой харьцуулбал 72 хувиар нэмэгдсэн хэмээн Нийслэлийн ИТХ-ын АН-ын бүлгийн дарга Ц.Баатархүү хэлж байна. Ер нь нийслэлийн төсвийн орлого жилд дунджаар 150 тэрбум төгрөгөөр нэмэгддэг байна. Гэхдээ үүнийг дагаад бидний амьдрах орчин, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн үү гэвэл үгүй. Чухам ийм л учраас уг нийтлэлээр хотын иргэн таны үүрэг

НИЙСЛЭЛИЙН ГОЛ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ



100
ГАРУЙ ЦЭЦЭРЛЭГ



100
ОРЧИМ СУРГУУЛЬ

ЗАМ ЗАСВАРЫН ЗАРДАЛ (ТЭРБУМ ТӨГРӨГ)

Дарь эхийн зам
2.2

Цагдаагийн гудамжны зам
3.4

Багануурын зам
185

Багахангайн зам
55

Налайхын зам
175

Нийслэлийн 2019 оны төсөв ©

Хотын удирдлагууд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор багагүй мөнгөтэй зээлийн багц баталчихаад байгааг та дуулсан уу. “Бичил зээлийг дэмжих хөтөлбөр”, “Нэг өрх-нэг ажлын байр”, “Улаанбаатарт үйлдвэрлэв” зэрэг хувийн хэвшилд зориулсан, хямд өртөгтэй эдгээр санхүүжилтийн нийт дүн нь 8.6 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байгаа. Бизнесийг чиглэх учиртай энэ мөнгө уг нь хийж бүтээх чин хүсэлтэй ч санхүүжилтээр гачигдаж яваа жинхэнэ жижиг, дунд бизнес эрхлэгчдэдээ хүртэл шар тос шиг санхүүжилтийн тус болох нь дамжиггүй. Харин жинхэнэ эзэндээ очилгүй, өмнө онд Монголын нийгмийг доргиосон тусгай сангуудын алдааг давтал манай шинэ цагийн түүхэнд хараар бичигдэх бараан жагсаалт улам уртасна гэсэн үг.

Хот хэмээх их айлын нэгдсэн төсвийн ард нуугдсан зарим тоог нийслэлийн иргэн танд зориулан тоймлон хүргэхэд ийм байна. 2019 он сонгуулийн өмнөх жил гэдэг утгаараа улс орон гэлтгүй аймаг, орон нутгууд хүртэл төсвийн орлого, зарлагаа багагүй хэмжээгээр тэлэхээр болсон. Тэгвэл

● Энэ онд нийслэлийн удирдлагууд Аз жаргалтай хотын индекс тооцож, сайжруулахад нэг тэрбум төгрөг зарцуулахаар төсөвт суулгажээ.

● Хувийн хэвшилд зориулсан, хямд өртөгтэй санхүүжилтийн нийт дүн нь 8.6 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна

● Нийслэлийн төсвийн орлого жилд дунджаар 150 тэрбум төгрөгөөр нэмэгддэг байна.

ИРГЭДИЙН ХАЛААСНААС ХОТЫН ТӨСВИЙГ ЧИГЛЭХ АЛБАН ТАТВАР

(тэрбум төгрөгөөр)

Хувь хүний орлогын албан татвар
495

Үл хөдлөх хөрөнгийн албан татвар
65.9

Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
27

Нийслэл хотын албан татвар
8

Нийслэлийн 2019 оны төсөв ©

оролцоо, санал санаачилга чухал болохыг дахин сануулж байна. Дотроо бухимдаж, чимээгүй бачимдлаа гээд баргар төрх бахь байдгаараа л үргэлжлэх нь. Харин элэгсэг, эх оронч ажил хэрэгчээр асуудалд хандаж, ухаалгаар иргэний эрх үүргээ биелүүлэхэд таны зүтгэл энэ хотод илүүдэхгүй болов уу. [ЗГМ]

Нийгэм



Түгжрэлийг бууруулах зорилгоор Энхтайваны өргөн чөлөө дагуу сургуулиудыг автобусаар хангах, үүний тулд чиглэл маршрутыг тодорхой болгох судалгаа хийж байна.

Б.Хасуй / ЗГМӨ

Хотын бүх сургуулийг автобустай болгоход 100 жил шаардлагатай юу

Нэг хичээлийн жилд төрийн өмчийн гурван сургуульд л автобус олгож байна

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

Өвлийн цагт нийслэлчүүдийг агаарын бохирдлоос гадна автомашины түгжрэл багагүй зуграадаг. Их түгжрэлээс болоод автобусууд нь явахгүй гацаж, иргэд буудал дээр дааран зогсдог дүр зураг өмнө нь байсан, өнөө ч хэвээрээ. Гэхдээ ойрын өдрүүдэд зам сэлүүхэн сайхан болсныг хүмүүс анзаарсан байх. Энэ нь хотын дарга нарын сайных биш л дээ. Харин сурагчдын амралт эхлэхтэй зэрэгцэн замын түгжрэл буурдаг зүй тогтол сүүлийн жилүүдэд ажиглагдах болов.

Бид өмнө нь хүүхдүүдээ зөвхөн харьяаллынх нь сургуульд явуулдаг байсан бол одоо байдал өөрчлөгдсөн. Боломжтой эцэг, эхчүүд хотын төвийн гайгүй гэсэн хэдэн сургуульд хүүхдээ оруулах гэж уралдаж байгаа. Улмаар өглөө, оройд хүүхдээ сургууль, гэрийн хооронд байнга зөөдөг нь түгжрэл үүсэх нэг шалтгаан болжээ. Харин сургууль амарсан үед замын түгжрэл 30-40 хувиар буурдаг болохыг замын цагдаагийн албаныхан тооцоолсон юм. Гэхдээ бид түгжрэлийг багасгана гээд сурагчдаа байнга амраагаад байж болохгүй. Хоёрдугаар улирлын амралт дуусангуут өнөөх гайхал түгжрэл дахиад л бий болно. Уг нь энэ асуудлыг бүгдэд хэрэгтэй байдлаар шийдэх нэг гарц нь сурагчдын автобус байгаа юм.



Жишээ татъя. Хувийн хэвшлийн “Хобби” сургууль энэ хичээлийн жилд хүүхдэд зөвхөн 12 автобустай үйл ажиллагаагаа явуулж буй. Хамгийн багадаа 250 хүүхэд хамрагдана гэсэн үг. Хэрэв тэрхүү 12 автобус байгаагүй бол хамгийн багадаа 250 машинтай эцэг, эх хүүхдээ хүргэж өгөх, авах гэж хотын төв рүү багагүй түгжрээ үүсгэх байлаа.

Нийслэлийн сурагчдын ердөө 2.6 хувь нь л автобусны үйлчилгээнд хамрагджээ

Харин хүүхдийн автобусны ачаар сургуулийн ойр орчимд үүсдэг байсан айхтар түгжрээ алга болсон байна. Манайхан сурагчдын автобусны энэ мэт давуу талыг ойлгодог, дэмждэг хэдий ч автобусаар хангах ажил бодит байдал дээр яст мэлхийний хурдаас ч удаан байна.

2018-2019 оны хичээлийн жилд

нийслэлийн долоон дүүргийн 52 сургуульд 130 автобус үйлчилж байгаа аж. Өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад автобусны тоо гурваар нэмэгдэж, Төрийн өмчийн 31 сургууль автобустай бол төрийн бус 21 сургууль байна. Эдгээр автобус 6784 сурагчийг тээвэрлэж байгаа гэх мэдээллийг нийслэлийн Боловсролын газраас өгсөн юм. Өдгөө нийслэлийн хэмжээнд 260 мянга орчим хүүхэд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа гэх статистикийн мэдээлэлтэй харьцуулж харвал нийт хүүхдийн ердөө 2.6 хувь нь л автобусны үйлчилгээнд хамрагджээ.

“Ерөнхийдөө хотын төвөөс алслагдсан, хүүхдүүд нь хол зам туулж очдог сургуулиудыг эхний ээлжинд автобусаар хангах бодлогыг улс баримталж байгаа. Гэхдээ сүүлийн үед сурагчдын автобус хүүхдийг аюул, осолгүй тээвэрлэхээс гадна түгжрэлийг бууруулахад нөлөөтэй юм байна гэж үзээд Энхтайваны өргөн чөлөө дагуу сургуулиудыг автобусаар хангах, үүний тулд чиглэл маршрутыг тодорхой болгох судалгаа хийгдэж байгаа. Засгийн газрын хөтөлбөр, нийслэлийн Засаг даргын мөрийн

хөтөлбөрт сургуулийн автобус төсөл хэрэгжүүлнэ гэж тусгасан. Гэхдээ нэг хичээлийн жилд төрийн өмчийн гурван сургуульд л автобус олгож байна” хэмээн нийслэлийн Боловсролын газрын Эрүүл ахуй, аюулгүй байдлын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Б.Энхтайван ярьсан юм. Сурагчдын автобусны үнэ үйлдвэрлэсэн он, маркаасаа шалтгаалаад янз бүр байх нь мэдээж. Манай улс дунджаар 150 орчим сая төгрөгөөр нэг автобус авдаг юм байна. Гэхдээ улс мөнгө муутай гэдэг шалтгаанаар жилд гуравхан автобус авах мөнгө төсөвлөсөөр өдийг хүрчээ. Энэ янзаараа бол нийслэлийн 240 сургуулийг бүгдийг нь ядаж ганц автобустай болгохын тулд 100 шахам жил хүлээх шаардлагатай болох нь. Арай ч дэндэнэ ээ.

● “Хобби” сургууль энэ хичээлийн жилд хүүхдэд зөвхөн 12 автобустай үйл ажиллагаагаа явуулж байна.

● Сургууль амарсан үед замын түгжрэл 30-40 хувиар буурдаг болохыг замын цагдаагийн албаныхан тооцоолсон.

● 2018-2019 оны хичээлийн жилд нийслэлийн долоон дүүргийн 52 сургуульд 130 автобус үйлчилж байгаа.

Уг нь байгаа нөөц, боломжоо ашиглавал бүх сургуулийг биш юмаа гэхэд нэлээд хэдийг нь автобустай болгочихож болмоор. Зундаа жуулчин зөөдөг автобусууд өвлийн цагт бол аль нэг гараашт дэмий зогсож л байгаа. Жуулчны компаниуд эдгээр автобусыг хүүхэд зөөхөд ашиглаж гэсэн хүсэлт

тавьдаг юм билээ. Гэвч сургуулийн автобусанд тавигдах стандартад нийцэхгүй гээд халгаадаггүй гэсэн.

Мөн АСЕМ-ийн үеэр ашиглахаар БНСУ-аас 43 автобусыг нийт 5.4 сая ам.доллараар худалдан авсныг бид мэднэ. Үүний 31-ийг нь зарим байгууллагад зээлээр өгснийг аудитын тайланд дурдсан байна лээ. Үлдсэн арав гаруй автобус өдгөө ашиглагдахгүй, дулаан зогсоолын төлбөрт дарагдан хэвтэж байгаа. Нэг бүр нь 125 мянган “ногоон”-ы үнэтэй эдгээр автобусаар ч хүүхэд зөөхөд болохгүй гэх газаргүй. Гэвч өнөөх стандартад нь нийцэхгүй тул бас л ашиглах боломжгүй. Сургуулийг автобустай болгоход хувийн хэвшлийнхэнтэй хамтран ажиллах ёстой гэж ярьдаг ч энэ мэт шалтгааны улмаас боломжоо алдсаар байгаа юм. Тиймээс стандартад өөрчлөлт оруулах замаар асуудлыг шийдэх боломжтой гэдгийг албаныхан хэлж байна.

Ямартай ч нийслэлийн Тээврийн газар, Боловсролын газар, Мэдээлэл технологийн газар, Замын цагдаагийн газар, Замын хөдөлгөөний удирдлагын төв гэсэн олон байгууллагын төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулагдаж, сургуулийн автобусны чиглэл гаргах, энэ нь түгжрэлд хэрхэн нөлөөлөх талаар судалгаа хийж эхэлсэн нь сайшаалтай. Гэхдээ өнөөх судалгаан нь хэзээ дуусаж, хэзээ шийдвэрээ гаргах юм, бүү мэд. Судалгаа хийж дууслаа ч гэсэн автобус авах шаардлагатай хөрөнгө мөнгийг шийдэж өгөх эсэх нь эргэлзээтэй. Энэ бүгдийг судалж, хэрэгжүүлэх гэсээр байтал нийслэлчүүд бид сурагчдын амралтад л найдахаас өөр сонголт алга. Амралт дууслаа л бол түгжрэлтэйгээ дахин нүүр тулна гэсэн сэтгэл зүйн бэлтгэлтэй байгаарай даа. [ЗГМ]

ОРОН НУТАГ

» БАЯН-ӨЛГИЙ

Баян-Өлгий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг энэ жил 11 мэргэжлээр 158 оюутан төгсөж байгаагаас 40 орчим хувь нь ажлын байрны урилга хүлээн авчээ. Тус сургуулийн захирал И.Жанболал “Бид ажлын байрны эрэлт хэрэгцээ, ажил олгогчдын захиалга дээр үндэслэн зөөгч бармен, автомашины күзөв засвар, мебель, модон эдлэлийн мужааны ангиудыг шинээр нээсэн” гэв.

» ХОВД

2019 онд Ховд аймагт нийтдээ 57 тэрбум хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг хийнэ. Тухайлбал, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төсөл, Цементийн үйлдвэрийн төсөл, жилдээ 50 мянган тонн газрын тос боловсруулах бага хүчин чадлын нефтийн үйлдвэр, эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх Ховд Агро парк, малын гаралтай түүхий эд, арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийн цогцолбор зэрэг томоохон ажлууд энэ онд эхлэх юм.

» ХӨВСГӨЛ

Мөрөн сумаас зургаан километр орших Хилэнтийн гүүрэн дээр хяналтын пост ажиллуулж эхэллээ. Энэ гүүрээр даац хэтрүүлсэн машинууд явж байгаагаас эвдэрч, нурж болзошгүй болдог учир эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Могойн голоос Хилэнтийн гүүрээр Эрдэнэтийн чиглэлд нүүрс тээвэрлэх үйл ажиллагааг дөрөвдүгээр сарын 1-н хүртэл Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлтээр зогсоож байгаа юм.

» СҮХБААТАР

Аймгийн хэмжээнд иргэдэд үнэт цаасны арилжааны данс нээх албан ёсны эрхтэй МОНСЕК гэх ганц брокер, диллерийн компани үйл ажиллагаа явуулж байна. Одоогоор тус компанид 30 орчим мянган иргэн данстай байгаагаас 11 мянга гаруй нь 2018 онд шинээр нээлгэжээ.

» ОРХОН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар ИТХ-ын энэ онд хийх ажлын төлөвлөгөөг батлахын сацуу “Түрээсийн орон сууц” дэд хөтөлбөрийг яаралтай боловсруулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст үүрэг болгоо.

» СЭЛЭНГЭ

Аймгийн хэмжээнд энэ сард агаарын температурын дундаж Орхон, Сэлэнгэ, Хараа, Ерөө голуудын хөндийгөөр 26-31 градус, бусад сумдын нутгаар 18-23 градус хүйгэн бууа олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй гэж аймгийн УЦУОШТ-өөс мэдээлэв. Энэ сард ихэнх сумын нутагт олон жилийн дунджаас ахиу цас орох төлөвтэй байгаа аж.

» УВС

Аймгийн Засаг даргын орлогч Т.Нямсамбуугаар ахлуулсан ажлын хэсэг Өлгий, Өмнөговь, Ховд, Бөхмөрөн сумдын нэгдсэн халаалт, өвөлжилтийн байдалтай танилцлаа. Өмнөговь, Ховд сумдын халаалт хэвийн хэмжээнээс доогуур байсан тул температурын горимыг мөрдөн ажиллах, шаардлага хангасан дулаан эрчим хүчээр хангах үүрэг өгчээ.

» ДУНДГОВЬ

Аймгийн хэмжээнд бүх нутаг дэвсгэрийг хамран мэдээлэл түгээдэг “Аюулаас сэргэмжлүүлэх цогцолбор” (АСЦ) зөвхөн FM 107.5-аар иргэдэд хүрдэг байсан бол одоо онлайнаар шууд хүрч, иргэдийн асуусан асуултад хариулт өгөх, санал хүсэлтийг хүлээн авах боломж бүрдлээ.

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Сүм хийд, шашны байгууллагуудад шалгалт явуулж байна



Нийслэлийн Онцгой байдлын газраас сүм хийд, шашны байгууллагуудад гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын төлөвлөгөөт бус шалгалтыг зохион байгуулж байна. Шалгалтаар сүм хийд, шашны байгууллагуудын барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнтэй

нийцүүлэн бүх нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан гамшгаас хамгаалах, галын аюулгүйн шаардлагыг тодорхойлсон стандарт, техникийн нормативын хэрэгжилтийг шалгаж, мэргэжил арга зүйн зааварчилгаа өгөх юм. Нийслэлд 163 сүм, хийд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хяналт шалгалт энэ сарын 25-ныг хүртэл үргэлжилнэ. [ЗГМ]

С.Чинзориг: Ирэх сард тэтгэвэр нэмнэ

Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт үндэсний хорооны хуралдаан боллоо. Энэ үеэр ХНХ-ын сайд С.Чинзориг энэ сараас төрийн албаныхны цалин, ирэх сараас тэтгэврийг нэмнэ гэдгийг хэлэв. Тэрбээр “Цалин нэмэгдүүлэх асуудлыг амжвал энэ долоо хоногт үгүй бол дараа долоо хоногт Засгийн газрын хуралдаанд оруулна. Засгийн газраас шийдвэр гаргасан даруйд би мэдээлэл өгөх болно. Төсөвт төрийн албан хаагчдын

цалин нэмэгдүүлэхэд зориулан 277 тэрбум төгрөг суусан. Мөн ахмадуудын тэтгэврийг нэмэгдүүлэхэд 119.5 тэрбум төгрөг төсөвлөсөн” гэлээ. Мөн халамжийн сангаас олгож буй тэтгэврийн хэмжээг амьжиргааны түвшинд хүргэж нэмэгдүүлэх зарчим баримталж байгааг мэдэгдсэн. Энэ дагуу халамжийн тэтгэврийг нэмэгдүүлэхэд нийт 22 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгажээ. Төрийн албан хаагчдын цалинг ажлын байрны нөхцөл,

ачаалал, хариуцлага, ур чадвараас хамаарч нэмэх учир ажлын байрны нөхцөлд үнэлгээ хийж байна. Энэ үнэлгээ судалгаанд үндэслэн албан тушаалын зэрэг дэвийн дахин тогтоох аж. Хуралдаанд ХНХЯ, БСШУСЯ, ХХААХҮЯ, МҮЭ-үүдийн холбоо, Монголын Ажил олгогч эздийн холбоо, Эрчим хүчний ассоциаци, Арьс шир боловсруулагчдын холбоо, Аж үйлдвэрийн Үндэсний зөвлөл зэрэг байгууллагын төлөөлөл оролцов. [ЗГМ]

Х.Цагаанбаатар УАШТ-д үзүүрлэв

Дэлхийн аварга, олимпын хүрэл медальт жүдоч Х.Цагаанбаатар Сэлэнгэ аймагт болж буй насанд хүрэгчдийн УАШТ-ээс мөнгөн медаль хүртлээ. Тэрбээр 90 кг-ын жинд хүч сорин финалд шалгарч, “Сүлд” спорт хорооны

тамирчин Э.Мөнхжаргалд ялагдсан юм.

Хөдөлмөрийн баатар Х.Цагаанбаатар 2015 онд жүдо бөхөө орхин дасгалжуулагчийн албанд шилжсэн. Өнгөрсөн хугацаанд залуучуудын шигшээ багийн

дасгалжуулагчаар ажиллаж байв. Мөн самбо, кураш зэрэг бөхийн бусад төрлөөр барилдсаар байсан. Тэгвэл энэ жил жүдогийн кимоноого дахин өмсөж, залууст үлдэх дуурайл үзүүлсээр медаль дээр буусан юм. [ЗГМ]

ЗГМ: Сэдэв

Энэ улсад чинь томуугийн тахал нүүрлэчихээд байгааг мэдэж байгаа хүн байна уу



Б.Хасуй / ЗГМ ©

өвдөх магадлал бага. Өвдсөн тохиолдолд хөнгөн өвдөнө. Харин вакцин хийлгээгүй, улирлын томуу тусч байгаагүй хүн хүнд өвдөх эрсдэлтэй.

Вакцин хийлгээгүй, улирлын томуу тусаагүй хүн хүнд өвдөх эрсдэлтэй

Шинээр мэндэлсэн хүүхдүүдээ, өндөр настай, дархлаа султай хүмүүс яах болж байна. Нийт өвчлөгсдийн 35 хувь нь 0-1 нас, 27 хувь нь 2-4 насны нялх балчрууд байна шүү дээ. Өнөөдрийн байдлаар зөвхөн нийслэлийн эмнэлгүүдэд 1700 орчим хүүхэд хэвтэн эмчлүүлж байна. “Энэ вирусээр нэг удаа өвдөг. Дараа нь дархлаа сууна” гээд зүгээр хараад суух уу. Ер нь энэ улсад чинь гахайн ханиадны тахал нүүрлэчихээд байгааг мэдэж байгаа хүн байна уу. Эцэстээ энэ бүх өвчлөл, ханиад аюулын харанга болтлоо даамжирна гэдэг эмнэлгүүд нь хүрэлцдэггүй, эмчилгээ бүрэн хийгддэггүй, дээрээс нь агаарын бохирдолтой л холбоотой. [ЗГМ]

Цагтаа 30 хүний амьдрал хүрсэн гахайн ханиад дахиад л дэгдлээ

Г.Санжааханд
ЗГМ

Шинэ жилийн баяраар эцэг эхчүүд хүүхдээ дагуулан гадуур их “тэнэсэн”, айл их “хэссэн” учраас ханиад, томуу огцом нэмэгдлээ гэх утгатай мэдэгдлийг хийж байх зуураа Эрүүл мэндийн яам “гахайн ханиад” нэрээр монголчуудтай танилцсан халдварт өвчин дахин дэгдсэнийг баталлаа. 2009 онд анх гахайн ханиад манай улсад гарснаас хэд хэдэн хүн нас барж, хурдацтай тархаж байсан. Хүнээс хүнд амьсгалын замаар болон ахуйн байдлаар халддаг уг вирус өнөөдөр жирийн нэгэн томуу шиг болтлоо манайд “нутагшжээ”.

Хүүхдээ тэвэрсэн эцэг, эхчүүд эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн үүдэнд урт дараалал үүсгэн зогсоно. Бага насны хүүхдүүд бүгд л цор цор ханиалгаж байлаа. Цээж нь хэржигнэн дуугарч, цэртэй ханиалгаж буй тэд өөрийн эрхгүй уйлна, цаанаа л нэг зовиуртай. Ээж, аавынхаа энгэрт наалдана. Харахад нүд хальтрам. Энэ дүр төрх улсын болон хувийн эмнэлгүүдэд ялгаагүй байв. Гэхдээ өвлийн өвөлд Улаанбаатарын эмнэлгүүдэд харагддаг энэ дүр төрхийг хэвийн мэт хүлээж авдаг Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн газар сүүлийн хэдэн жил дорвитой арга хэмжээ авсангүй. “Хүүхдийн ор нэмж тавилаа”, “эмч нарыг уртасгасан цагаар ажиллуулж байна” гэхээс өөр шийдэл гаргадаггүй дүлий төрдөө хүүхэд, нялхсынхаа өмнөөс гомдоод байх юм.

Яармагт байрлах Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгт очив. Хүүхдүүд өвчиндөө зовиурлаж, аргаа барсан эцэг эхчүүд дэмий л шаналж, ачаалалдаа дарагдсан эмч нар бухимдсан дүр төрх биднийг угтлаа. Эцэг эхчүүд “Хүүхэд өндөр халуураад, амьсгаа нь боогдчих гээд их хэцүү ирсэн. Гэхдээ эмнэлэгт ирээд ч нэмэр

алга. Харин ч газраар хэвтэж, олон хүүхдүүд, эцэг эхчүүдийн уйлаан майлаан, дуу чимээнд тавгүй байна. Эмнэлэгт байгаа учраас аргагүйдэхэд эмч нарын хажууд юмдаа л гэж бодох юм” хэмээн ярина. Нэг ой гарантай охиноо сахин хэвтэж буй өөр нэгэн ээж “Хүүхэд маань өндөр халуураад, амьсгаа нь боогдчих гээд их хэцүү байна. Ханиад тусаад шууд л хатгаа болсон. Эмнэлэгт ирэхэд ор байхгүй, коридорт л охиноо сахиад хэвтэж байна” гэсэн юм.

● **Хүнээс хүнд амьсгалын замаар болон ахуйн байдлаар халддаг уг вирус өнөөдөр жирийн нэгэн томуу шиг болтлоо манайд “нутагшжээ”.**

● **Хүүхдүүд өвчиндөө зовиурлаж, аргаа барсан эцэг эхчүүд дэмий л шаналж, ачаалалдаа дарагдсан эмч нар бухимдсан дүр төрх биднийг угтлаа.**

● **Шинээр мэндэлсэн хүүхдүүдээ, өндөр настай, дархлаа султай хүмүүс яах болж байна. Нийт өвчлөгсдийн 35 хувь нь 0-1 нас, 27 хувь нь 2-4 насны нялх балчрууд байна шүү дээ.**

Хамгийн аюултай нь гахайн ханиад буюу H1N1 жил бүр шинж чанараа өөрчлөх болсон учраас эмчлэх арга зүйг ч тухай бүрт нь шинэчлэн боловсруулж байх шаардлага тулгардаг. Мөн хүмүүст энэ төрлийн вирусны дархлаа суугаагүй учраас монголын нялхас, багачууд жилийн жилд л олноороо өвдсөөр. Гэвч манай бодлого тодорхойлогчдын урьдчилан сэргийлж буй ганц арга нь ид хүйтнээр сурагчдыг амрах. Мөн ч ядарсан арга, зүдэрсэн зохицуулалт гэдгийн баталгаа нь өнөөдөр эмнэлгийн ор

байтугай шалаар нь зулж хэвтээд ч багтахаа байсан бага насны хүүхдүүдийн өвчлөлийн тоо.

Харин ЭМЯ “Он гарснаас хойш А хүрээний вирусүүд буюу H1N1, H3N2 зэрэг улирлын томуу гарч эхэлсэн. Энэ нь томуу, томуу төст өвчнийг бодвол хүндрэл ихтэй, бага насны хүүхдүүд уушгины хатгалгаа амархан хүрэх эрсдэлтэй” хэмээн мэдээлэв. Монголд дэгдсэнээсээ хойш гурван жилийн хугацаанд 30 хүний амь насыг авч одсон энэ вирусын талаар ингэж хэнэггүй ярьж, хойрго хандаж болно гэж үү.

Салбарын яамны эвэртэн, туурайтан ингэж ярьдаг юм байж, харин мэргэжлийн эмч мэргэжилтнүүд H1N1 вирусны дэгдэлтийн талаар ямар байр суурьтай байгааг нь тодруулахаар ХӨСҮТ-ийн Томуугийн үндэсний нэгжийн дарга А.Бурмаатай холбогдон дараах тодруулгыг авлаа.

-Он гарснаас хойш Томуугийн А хүрээний (H1N1, H3N2) вирус нэмэгдсэн талаар ЭМЯ-наас мэдээлсэн. Энэ вирус олон жилийн өмнө гарч байсан гахайн ханиад мөн үү?

-Тийм ээ. 2009 оноос хойш жил бүр гардаг ханиадны дэгдэлт. Томуугийн хүрээний вирус буюу гахайн ханиадны тохиолдол манай улсад анх 2009 онд гарч байсан. Тэр үед шинэ төрлийн вирус байлаа. Тухайн үед дархлаагүй байсан хүмүүс илүү хүндээр тусч олноороо халдварт өртөж, нас барж байсан. Гахайн ханиадны цар тахал нь 20-30 жилд нэг удаа гардаг. Манай улсын хувьд 10 жилийн турш дэгдэлт нь гарч байна. Сүүлийн үед улирлын томуу гэж нэрлэх болсон. Хүйтний эрч чангарч байгаа болохоор жил бүр дэгдэлт гараад байгаа.

-Бусад вирусээс юугаараа ялгарах вэ?

-А вирус нь хувьсаж өөрчлөгдөж, шинэчлэгдэж байдаг хувьсамтгай чанартай. Улирлын томуугийн дэгдэлт үүсгэдэг. Бага насны хүүхдүүдийг хүнд өвчлүүлдэг вирус болох нь эмнэлгүүдээс авч буй шинжилгээгээр илэрсэн.

-Томуугийн вакцин хийлгэсэн тохиолдолд А хүрээний вирусээс хамгаалж чадах үү?

-Вакцин хийлгэлээ гээд 100

хувь ханиад хүрэхгүй гэсэн үг биш. Энэ жилийн томуугийн вакцины найрлаганд H1N1

болон H3N2 орсон. Вакцин хийлгэсэн болон өмнө нь улирлын томуу тусч байсан хүн

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 01 дугаар сарын 09-ний өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Агаар орчны бохирдлыг бууруулах техник, технологийн мэдээллийн төв байгуулах үл хөдлөх хөрөнгө нийлүүлэх ажил
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: НХААГ-18/0099

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос **Агаар орчны бохирдлыг бууруулах техник, технологийн мэдээллийн төв байгуулах үл хөдлөх хөрөнгө нийлүүлэх тухай цахим тендер** ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50 000 (тавин мянга) төгрөгийг** банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендер нь дараах багцаас бүрдэнэ: **Багцгүй.** Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жилийн (2016, 2017, 2018 он) дундаж борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн 50 хувиас багагүй байна. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх.

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 оны аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх.

Ижил төстэй ажилд үл хөдлөх хөрөнгө нийлүүлсэн туршлагыг тооцно. **Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** Үгүй Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ. **3 000 000 /гурван сая/ төгрөг**

Тендерийг **2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 15 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 15 цаг 30 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй. Дотоодын давуу эрх тооцно. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn, www.ub-procurement.mn цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15, Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 дугаар давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810.

ZGM DAILY

4,136 people diagnosed with influenza in a single week

Majority or 35.6 percent of patients were infants aged 0 to 1.

Khuvsgul Altan Duulga JSC stock price jumps 22 times in one year

As of the end of 2018, 73.9 percent stake of the company is owned by four major shareholders.

Foreign trade turnover reached USD 12.8 billion in December 2018

This is 22.3 percent higher compared to the same period of last year.

MIAT plans to relocate to the new airport by July

Relocation is expected to increase administrative expense by over 10 percent.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

Ambassador of Mongolia to the Republic of Korea Ganbold Baasanjav was appointed as the Head of Subregional Office for East and North-East Asia of the United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific (ESCAP). Ambassador Ganbold also serves as the Special Envoy for Sustainable Development at the Ministry of Foreign Affairs since October, 2018.

ECONOMY

Within the frames of Blue Pearl program, auto road construction from Khatgal Village to Khankh soum of Khuvsgul aimag is expected to begin in 2019 with USD 20 million in financing from the Asian Development Bank. Additionally, a bill on Protection of Khuvsgul Lake has been drafted and is expected to be submitted to the Parliament this spring. The ratification of the bill will allow annual financing for protection of Khuvsgul Lake from the State Budget.

Top 20 Index falls 0.24 percent, to 21,822.04 points. MSE A Index decreases 0.2 percent, to 10,247.01 points. MSE B Index falls 0.45 percent, to 8,788.66 points. Market cap stands at MNT 2.54 trillion.

SOCIETY

Minister of Health Sarangerel Davaajantsan meets the steering committee of MON-8, a project on establishment of a National Diagnostic and Treatment Center and had an au fait with the construction process. The construction is currently 97 percent complete and 1580 out of 1870 medical equipment have been installed. The medical center is expected to commission on March 31.

At the request of Mongolian Wrestling Federation, United World Wrestling updates the scheduled events for 2019, adding the U23 Senior Asian Championships to take place on March 24-26 in Ulaanbaatar, Mongolia.

Leo Delibes' Coppelia, also known as The Girl With The Enamel Eyes, to be performed at the National Academic Theatre of Opera and Ballet of Mongolia on January 12.

Scan the QR code for further information and to purchase the ticket.



Children overcrowd hospitals due to swine flu outbreak



Hospitals exceed capacity with increased beds and immediate measures

Batsaikhan.S / ZGM©

Influenza calls account for 59.5 percent of children's emergency service

Sanjaakhand.G, Tugsbilig.B
ZGM

Regardless of immediate measure to increase capacity by adding additional beds, hospitals overcrowded with children suffer-

ing from influenza and common cold. In the first week of this year, a total of 4,136 instances out of 57,508 ambulatory care were diagnosed with influenza or similar illness in the capital city alone.

35.6 percent of patients were infants aged 0 to 1, 26.8 percent were aged 2 to 4 and 14.4 percent were aged 5 to 9. Out of 3,098 calls at children's emergency services, 59.5 percent were influenza or similar illness calls. As a city-wide measure, 977 additional children's beds and 695 hospital beds were

installed at hospitals in the first week of 2019. As of today, a total of 1672 children are being treated at hospitals. A study conducted by the Ulaanbaatar city Health Department (UBHD) shows that 850 more children's bed can also be installed at hospitals.

Sources say the majority of the patients were diagnosed with H1N1 virus, which forced the entire city to go into a quarantine a few years ago. A spokesperson of the UBHD remarked, "Influenza A virus subtype H1N1 is one of


the common flu that annually outbreaks in Mongolia. The first outbreak of the virus, which is also called swine flu or pig flu, was in 2009. As a new virus, the symptoms were more severe and spread more easily, leading to several deaths, as the public was not immune to the virus. This kind of pandemic happens once every 20-30 years. As for Mongolia, influenza outbreaks are happening in every decade. After the 2009 breakout, H1N1 is now called respiratory flu. Main cause

of the near-frequency is the cold weather."

He then explained that the flu is highly contagious to people with low immunity, chronic illness, elders and children. "Since the first global epidemic of swine flu, people developed immunity towards it; however, the virus evolves constantly, leading to a seasonal flu outbreaks."

According to officials, the influenza vaccine of this year comprises of H1N1 and H3N2 virus components. [ZGM]

FX MARKET



STOCK MARKET

Khuvsgul Altan Duulga stock jumps 22 times

Sanjaakhand.G, Tugsbilig.B
ZGM

Mongolian Stock Exchange Tier-II listed firm Khuvsgul Altan Duulga JSC's stock price jumped by 22 times to MNT 900 per share within a year.

The company, which owns a farm, flour and fodder factories in Tarialan soum of Khuvsgul aimag, offered a seasoned issue last year, raising MNT 3.7 billion from the public. Accordingly, the company expanded its operations and began selling its products in Ulaanbaatar city. As a result, the sales revenue of Khuvsgul Altan Duulga grew by over 50 percent last year.

As of the end of 2018, 73.9 percent stake of the company is owned by four major shareholders and the rest are held by 240 small shareholders. [ZGM]

TRADE

Foreign trade balance falls to USD 1.1 billion despite 13.1 percent export growth



Khasui.B / ZGM©

According to Customs Authority, foreign trade turnover reached USD 12.8 billion in December 2018, which is 22.3 percent higher compared to the same period of last year.

Within the same period, export grew by 13.1 percent, while import had an upsurge of 35.5 percent. Jump in imports lowered the balance of trade to USD 1.1 billion from USD 1.8 billion in 2017. Trade balance fell even though coal exports surpassed its

annual plan by November.

The Government is planning to export 42 million tons of coal in 2019. Within the frame, the capacity at Gashuunsukhait-Gantsmod border checkpoint has been doubled. Customs authority noted that the checkpoint can allow entry to over 2000 vehicles per day.

On the other hand, import surged by 35.5 percent last year. The Bank of Mongolia previously explained that investment products and industrial supplies

accounted for the majority of imports, highlighting that the growth in import will have positive impact on economy in the mid-term. The bank took several policy measures with an aim to limit the growing imports and prevent foreign exchange risks, which took effect this month. Economist Enkhbayar Namjildorj also suggested that "Mongolia is in need for an agency specifically responsible for foreign trade policy." [ZGM]

AVIATION

MIAT: Relocation will not change ticket prices



Following Prime Minister Khurelsukh Ukhnaa's order to commence Khushing Valley International Airport this year, MIAT Mongolian Airlines informed that the company is planning to move to the newly constructed airport by July.

According to MIAT officials, the relocation is expected to increase administrative expense by over 10 percent, but ticket prices will remain unchanged. Further-

more, direct flights to Shanghai and Guangzhou are expected to open this summer.

The Maintenance and Engineering center of MIAT airlines completed the repairs of 12 aircraft last year, earning MNT 11 billion. The company has reportedly signed around 20 maintenance agreement this year. As of today, the company is cooperating with Russian, South Korean and Thai airlines in maintenance services. [ZGM]

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР



- 07.00 "Өглөө" хөтөлбөр /шууд/
- 10.05 Онцгой дуудлага
- 16.45 "Урлаг" теле сэтгүүл
- 18.30 Иргэдийн эрхзүйн боловсролд /шууд/
- 19.40 Технологийн ертөнцөөр
- 21.05 "Нээлттэй хором" нийгмийн ток шоу /шууд/

Bloomberg TV Mongolia

- 07.00 "Өсөлтийн замд" нэвтрүүлэг
- 11.00 "#Made in Mongolia" баримтат нэвтрүүлэг
- 11.30 "Удирдагчид Лакуатай хамт" нэвтрүүлэг
- 14.30 "Хариуцлага ба үнэ цэнэ" нэвтрүүлэг
- 21.00 "Мөнгөний урсгал" мэдээний хөтөлбөр
- 22.30 "Ногоон хот" нэвтрүүлэг


БОЛОВСРОЛ HD

- 07.00 "Зураглал"
- 09.55 Хөгжмийн завсарлага
- 11.20 "Үүнийг хэрхэн хийдэг вэ?"
- 14.10 "Ялалт ток шоу" нэвтрүүлэг
- 20.35 "Дэлхийн атлас" нэвтрүүлэг
- 20.50 "Гал тогоо" шоу нэвтрүүлэг



- 06.00 Сонсье, Суръя, Дагая /season-1/ 3-р анги
- 10.25 Цаг агаарын хөтөлбөр
- 12.00 "Хөтөч" мэдээллийн хөтөлбөр
- 13.30 "Ан амьтдын ертөнцөөр" /season-9/ 23-р хэсэг
- 19.00 "Оргил цаг" мэдээллийн хөтөлбөр
- 21.30 "Америкчууд" ОАК / season-6/ 8-р анги

ЗУРХАЙ



Билгийн тооллын 3
Өвлийн адаг хөхөгчин үхэр сарын нэг цагаан мэнгэтэй улаан морь өдөр
Үс засуулбал: Эд мал баялаг төгөлдөр болно
Наран ургах, шингэх: 08.35-17.22
Барилдлага: Рашаан
Шүтэн барилдлага: Тийн мэдэхүй
Суудал: Мод

Аргын тооллын нэгдүгээр сарын 9, Буд гараг. Билгийн тооллын 3, Тооно одтой, улаан морь өдөр.

Өдрийн наран 08.35 цагт мандан, 17.22 цагт жаргана. Тухайн өдөр бар; нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, угаал үйлдэх, тангараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд малтай баялаг төгс болно.



Coaching Wednesday
Хэзээ: 2019.01.09
Хаана: The Corporate Hotel & Convention Centre EVENT
Тасалбарын үнэ: ₮10 мянга



"Цэнхэр нүдэн бүсгүй" бүжгэн жүжиг
Хэзээ: 2019.01.12
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга



"Уран хас" бүжгэн жүжиг
Хэзээ: 2019.01.19
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга

ОНЦЛОХ ҮЗВЭР

"Тамгагүй төр"-тэй өдрүүд



Хаан Арчугт их хатан Цэцэр, бага хатан Гүргэл нар нуган үр төрүүлж өгсөн нь хурмаст тэнгэр, хувь заяаны даажигнал байлаа. Үр заяах нь байтугай үнэрийг нь мартсан эх хатныхаа хүүг өөрийнх нь биш гэдгийг хаан мэдэж буй тул бага хатнаасаа төрсөн хүүгээ өлгийтэйд нь хаанд өргөмжлөхөөр зарлиг буулгалаа. Хааны итгэлт шадар Эгэрэг энэ зарлигийг эсэргүүцэвч яаж ч чадахгүй буцахдаа их хатан

Цэцэрийн хэвлийгээс төрсөн нууц хүүгээ бага хатны хүүтэй арга буюу солив. Хаан Арчуг хүүгээ татаж унадаг өвчтэй, санаа муутай болохыг нь өсч том болоход нь мэдэн гуниглаж, хаан ширээнд тохирох хүн биш хэмээн яллаж, хорооно. Хайрт хатан Гүргэлээ ч мөн хүүгээ алдсан шаналалдаа цөхөрч суухыг нь харж дийлэхгүй тул егүүтгэнэ. Харин хааны шадар, санаа муут Эгэрэг энэ бүхнийг зогсоож

үл чадаад хорын сэтгэлдээ автахдаа хааны жинхэнэ хүүг хороон, өөрөө төрийн тамга, түмний эрхийг авахаар хаантай тэрсэлдэнэ. Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэнгийн "Тамгагүй төр" түүхэн жүжгийг Урлагийн гавьяат зүтгэлтэн Ч.Найдандоржийн найруулснаар энэ сарын 18-20-нд 18.00 цагаас УДЭТ-ын тайзнаа тоглоно. Тасалбарын үнэ 10-25 мянган төгрөг. [31M]



"Жаргагүй нар" жүжиг
Хэзээ: 2019.01.24
Хаана: УДЭТ
Тасалбарын үнэ: ₮10-25 мянга



"Хунт нуур" бүжгэн жүжиг
Хэзээ: 2019.02.02
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮10-30 мянга



"Травиата" дуурь
Хэзээ: 2019.02.03
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга

ЦАГ АГААР

УЛААНБААТАР





ФОТО АГШИН



Амарч, агаарлахдаа ч аюулгүй байдлыг сахих хэрэгтэй.

С.Батсайхан / ЗГМ©

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:

- Олсон зүйл
- Эрэгчин бор гөрөөс
- Нас гүйцсэн эрэгчин янгир
- Амьтдын ичээ, байр
- Есөн эрдэнийн нэг
- Нисэх болон усан тээврийн

хэрэгсэл

- ... нутаг
- Зөвлөлт Холбоот Улсын анхны удирдагч
- Яаруу тэвдүү
- Нөхөн сонгууль
- Буйд

ХӨНДЛӨНГӨӨР:

- Төл мал
- Нэгэн телевиз
- Төл мал
- Төв аймгийн Дэлгэр хаан сумын нутагт байдаг нэг уул
- Өндөр гэхийг шоглон нэрлэдэг нэр
- Хувцас
- Завхан аймгийн харьяат арслангийн энгэй гэгддэг гарьд



Өмнөх дугаарын хариу / 01.08

ЗГМ: СУДОКУ

		1						4
		9	8	6				
7	1	5						
3	9	7						
					8			
		1	6	7	3			5
8			6		4			1
1	5				2			8
		3			5			

6	1	5	8	3	7	4	2	9
8	7	3	9	2	4	6	5	1
9	2	4	1	6	5	8	7	3
5	8	1	4	7	2	9	3	6
4	3	6	5	9	8	2	1	7
7	9	2	3	1	6	5	8	4
3	6	8	7	5	9	1	4	2
2	4	7	6	8	1	3	9	5
1	5	9	2	4	3	7	6	8

(Index нөмрөө АГ хөнгө)



ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

ЭРЭЭН-УБ	18.00	11.15
УБ-ХӨХ ХОТ	20.00	20.49
ХӨХ ХОТ-УБ	22.50	11.15
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-СҮХБААТАР	21.15	05.12
СҮХБААТАР-УБ	20.55	05.03
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48
УБ-ЗАМЫН-ҮҮД	17.20	07.05
ЗАМЫН-ҮҮД-УБ	17.35	08.55



НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-БЭЭЖИН	17.15	19.30
БЭЭЖИН-УБ	20.30	23.00
УБ-ХОНКОНГ	07.50	12.25
ХОНКОНГ-УБ	13.25	18.05
УБ-СӨҮЛ	07.45	12.05
СӨҮЛ-УБ	13.20	16.05
УБ-ТОКИО	08.55	14.30
ТОКИО-УБ	15.30	20.25
УБ-ХӨХ ХОТ	10.30	12.00
ХӨХ ХОТ-УБ	13.00	14.40
УБ-ЭРХҮҮ	06.20	07.20
ЭРХҮҮ-УБ	08.20	09.20

ЭДИЙН ЗАСАГ

Эм үйлдвэрлэлийн салбарыг өөрчлөгч 62 тэрбумын хэлцэл

Нэгтгэх ажиллагааны эцэст Takeda компани дэлхийн шилдэг 10 эм үйлдвэрлэгчийн нэг боллоо.

> 10

Хятадаас үүдэн Goldman Sachs үнийн таамгаа өөрчлөв

Goldman нь 2019 онд түүхий эд материалын үнэ, нийлүүлэлт өсөх байр суурь баримталж байна.

> 10

Дэлхийн Банкны ерөнхийлөгч гэнэт огцорлоо

Дональд Трамп Дэлхийн Банкны шинэ тэргүүнээр өөрийн талын хүнийг нэр дэвшүүлж болзошгүй.


> 10



Microsoft-ын хувьцааны үнэ даваа гарагт ердөө 0.1 хувь өссөн тул гол өрсөлдөгчдөө байр сууриа алдав.

АНУ, Хятадын худалдааны хэлэлцээний гол 7 асуудал

Худалдааны дайнд хамгийн их хохирсон салбарууд (Жилийн орлогын уналт хувиар)



Даваа гарагт Бээжинд эхлээд буй АНУ, Хятадын худалдааны дунд шатны хэлэлцээ түр эвлэрлийн 90 хоногт багтаан тохиролцоонд хүрэх болов уу гэсэн найдвар төрүүлж буй. Гэвч хоёр талыг худалдааны дайнд хүргэсэн дараах долоон асуудал шинжээчдийн анхаарлыг татаж буй.

1. ОЮУНЫ ӨМЧ

АНУ Бээжин Америкийн компаниудын нарийн технологийг албадан авах буюу оюуны өмчийг хулгайлж байна хэмээн буруутгасан нь шийдвэрлэхэд хамгийн төвөгтэй бөгөөд хэлэлцээг тасалдуулж болзошгүй гол асуудал юм. Хоёр талын уулзалтын явцад оюуны өмчийн хамгаалалт, цахим хулгай, технологи шилжүүлэх талаар Хятадын хандлагыг авч үзнэ. Бээжин оюуны өмчийн хулгайд холбогдсон компаниудаа шийтгэх, хязгаарлах арга хэмжээ зарласан боловч хэрэгжилт тодорхойгүй байгаа.

2. HUAWEI БА 5G

Хятадын телекомын тэргүүлэгч Huawei компанийг Вашингтон төрийн дэмжлэгтэйгээр тагнуул хийдэг хэмээн буруутгасан. Тус компани 5G технологи хөгжүүлэхээр амжилттай урагшилж, дэлхийн амин чухал патентын арван хувийг эзэмшдэг. Гэтэл Цагаан ордон тус тоног төхөөрөмжийг засаг захиргааны хэрэгцээнд худалдан авахыг хориглож, холбоотнууддаа ч мөн анхааруулсан. Huawei-н санхүүгийн захирал Мэн Вэнжоуд Ираны эсрэг хориг зөрчсөн хэрэг тулгаж Канадад баривчилсны дараа Бээжин Канадын хоёр иргэнийг саатуулаад байгаа.

3. ХЯТАДАД ҮЙЛДВЭРЛЭВ 2025

Бээжингийн "Made in China 2025" төлөвлөгөө Хятадыг робот, цэвэр эрчим хүч, био технологи зэрэг 10 салбарт тэргүүлдэг улс болгох зорилготой. Ийм эрмэлзэлд Цагаан ордон зэвүүцэж, төрийн оролцоо ДХБ-ын дүрмийг зөрчиж, гадаадын тоглогчдоод шударга буса хандлага бий болгоно хэмээн шүүмжилдэг. Трампын тариф уг төлөвлөгөөнд багтсан салбаруудыг чиглэж байгаа. Хятадын тал урт хугацааны эдийн засгийн зорилгыг хэрэгжүүлэх стратеги хэмээн тайлбарладаг. Гэвч худалдааны дайныг намжаахад дэм үзүүлэх бол Бээжин уг төлөвлөгөөг засахад бэлэн байгааг нэг эх сурвалж мэдээлсэн.

4. ЭРЧИМ ХҮЧ

АНУ нефть, байгалийн хийн томоохон экспортлогч, Хятад гол импортлогч болж байгаа үед хоёр тал энэ талаар тохиролцож чадвал хэн хэнд нь ашигтай. Гэвч худалдааны дайны улмаас саатаад буй. Трампын тарифын хариуд Бээжингийн зүгээс Америкийн шингэрүүлсэн хийн импортод ногдуулсан импортын татварыг бууруулахаас гадна Хятадын компаниудын эргэлзээг арилгаж, уг салбарт хөрөнгө оруулахад дэмжлэг болно. Одоохондоо Хятадын тал АНУ-аас түүхий нефть оруулахад хориг тавиагүй байгаа нь хэлэлцээнд дөхөм болж магадгүй.

5. ХАА-Н БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ

Хятад улс АНУ-ын төв нутгийн фермерүүдэд хүнд цохилт болсон эрдэнэ шиш, хөвөн, шар буурцаг, гахайн маханд харуу хаалт тавьснаа цуцлах эсэхийг хөрөнгө оруулагчид анхааралтай ажиглаж байна. Түүнчлэн хатаасан үр тариа, тахианы мах зэрэг бүтээгдэхүүний тарифыг багасгавал Америкийн үйлдвэрлэлүүд түргэн сэргээнэ. Гэвч худалдааны хэлэлцээ амжилтад хүрэхгүй бол Хятадын тал өмнөх захиалгаа ч цуцалж магадгүй юм.

6. АВТЫН ТАРИФ

Бээжин АНУ-аас импортлох автомашинд 25 хувийн шийтгэх тариф ногдуулсан боловч энэ сарын нэгнээс түр цуцлаад байгаа. Нэмэлт тариф АНУ-д байрладаг Tesla, BMW, Daimler гээд бүх үйлдвэрлэгчдэд хохирол учруулсан. Дэлхийн хоёр том эдийн засгийн худалдааны сөргөлдөөнийг намжаах зөвшилцөлд хүрвэл машин үйлдвэрлэгчдэд таатай нөхцөл бүрдэнэ.

7. БАНК, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хятадын эрх баригчид гадаадын эзэмшилтэй санхүүгийн фирмүүдийг зах зээлдээ оруулахыг амласан. 11 дүгээр сард UBS групп дотоодын хамтарсан үйлдвэрийн дүрмийн дагуу үнэт цаасны хяналтын эрх авсан анхны гадаадын банк болжээ. JPMorgan Chase, Nomura Holdings банкууд эх газрын Хятадад 51 хувийн багц авах зөвшөөрөл хүлээж буй. Ерөнхийлөгч Ши Жиньпин гадаад, банк болон үнэ цаасны компаниуд 2030 он гэхэд 32 тэрбум ам.долларын ашиг олох боломж бүрдэнэ гэж мэдэгдсэн.

Amazon хамгийн өндөр үнэлгээтэй компани боллоо

Райан Властелика

Онлайн худалдааны Amazon компани даваа гарагт зах зээлийн үнэлгээгээр Microsoft-оос жаахан давсан учир Уол Стритийн томчуудын жагсаалтыг тэргүүлж, хамгийн өндөр үнэлгээтэй компани болсон байна. Цахим арилжааны компанийн хувьцааны үнэ 3.4 хувиар өссөн явдал Amazon-ий нийт үнэлгээг 797 тэрбум ам.долларт хүргэснийг Bloomberg агентлаг мэдээлэв. Өнгөрсөн оны

есдүгээр сард Amazon нэр тэрбум ам.долларын босгыг давсан боловч технологийн хувьцааны ерөнхий уналтын дараа үнэлгээ доошилсон. Гэтэл дэлхийн хамгийн үнэ цэнтэй компаниудын жагсаалтыг тэргүүлж байсан Microsoft-ын хувьцааны үнэ даваа гарагт ердөө 0.1 хувь өссөн тул гол өрсөлдөгчдөө байр сууриа алдав. Технологи, интернэгийн аваргуудын урд хойно орсон ийм хөөцөлдөөн хэдэн сарын турш


үргэлжилж, арванхоёрдугаар сарын эхээр Amazon богино хугацаанд аваргын титмийг авсан. Хоёр компанийн тус тусын үнэлгээ тэргүүн байрыг олон жил хадгалсан Apple-ийнхаас нэлээд давж гараад буй.

iPhone үйлдвэрлэгч аравдугаар сарын эхээр 1.1 их наяд ам.долларын босгыг алхсан боловч одоо 702 тэрбум дээр буугаад байна. Үүний гол шалтгаан нь Хятадад iPhone-ий эрэлт

таамгаас доогуур байгаа явдал гэж үздэг. Өнгөрсөн долоо хоногт тус компани борлуулалтын төлөвөө доошлуулсны дараа хувьцааных нь үнэ уруудаж, 2017 оны дөрөвдүгээр сараас хойш хамгийн доод түвшинд иржээ. Одоо Apple АНУ-ын хувьцааны зах зээлд дөрөвт жагсаж байна. Google-ын толгой компани болох Alphabet Inc., 745 тэрбум ам.долларын үнэлгээгээр гуравдугаар байрт бичигджээ.

Samsung технологийн борлуулалт буурсны горыг амсаж эхлэв

Дэлхийн гар утасны зах зээлд Хятадын компаниуд түрж байна (Зах зээлд эзлэх хувь хэмжээ)



Сэм Ким

2018 оны сүүлийн гурван улиралд санах ойн чипний эрэлт буурсан учир Samsung компанийн улирлын ашиг ба борлуулалт таамагт хүрсэнгүй.

12 дугаар сараар дуусгавар болсон улиралд Өмнөд Солонгосын компанийн үйл ажиллагааны орлого 9.65 тэрбум ам.доллар байсан нь Apple-ынхтай төстэй үзүүлэлт боллоо гэж шинжээчид

тэмдэглэв. Samsung-ын хоёр том зах зээл болох Хятад, АНУ-ын худалдааны зөрчил хурцалсан явдал тус компанийн ухаалаг утаснаас эхлээд санах ойн чипний эрэлтийг буурууллаа.

Apple сүүлийн 20 жилд анх удаа борлуулалтын төлөвөө бууруулсан явдал өнгөрсөн долоо хоногт зах зээлд цочрол өгсөн. Hi Investment фирмийн шинжээч Сон Миун Сап "Зөвхөн Apple ч биш, ухаалаг утас, сервер, компьютерын худалдаа саарч байна. Худалдааны дайн нөмрөөд байгаа үед хэрэглэгчид чипний үнийг буулгахыг хүлээж байна" хэмээн тайлбарлав. Дөрөвдүгээр улиралд Samsung-ын борлуулалт 59 их наяд вон байсан бол таамаг 63.6 их наяд байв. Эднийх цэвэр ашгийн хэмжээг сарын сүүлээр нарийвчилсан тайландаа мэдээлэхээ амласан. Уг мэдээллийн

дараа Сөүлд тус компанийн хувьцааны үнэ 2.1 хувь унасан бол өнгөрсөн жилд нийт 24 хувиа алдсан. Санах ойн чип Samsung-ын ашгийн үлэмж хувийг эзэлдэг. Гэвч 32 гигабайтын DRAM серверийн үнэ сүүлийн улиралд таван хувь багасжээ.

Apple гэнэт төлөвөө танасан явдал Samsung-ын захиалгад сөрөг нөлөө үзүүлнэ. Америкийн компани Samsung-аас санах ойн чип болон ухаалаг утасны дэлгэц худалдан авдаг хамгийн том захиалагч гэж Bloomberg мэдээлсэн. Өмнөд Солонгосын компани шинэ оны эхний улиралд чипний бизнес бэрхшээл тулгарна гэдгийг хүлээн зөвшөөрчээ. Түүнчлэн тус компанийн шингэн кристал дэлгэцтэй телевизорт Хятадын компаниудын зүгээс хүчтэй өрсөлдөөн ирж байна.

Британид гадаадынхан ажиллахад таатай хэвээр үлдэнэ



Британи Европын холбооноос гарах хүнд үйл явцыг тулж байгаа хэдий ч гадаадын иргэд албан тушаал ахихад таатай эсэх үзүүлэлтээр байр ахисан байна. HSBC банкнаас явуулсан судалгаанд тус улс зургаан байраар дээшилж, Герман, Бахрейны дараа гуравт бичигдлээ. Их Британи шинэ мэдлэг олж авах шалгуураар нэгдүгээрт, албан тушаал ахих боломжоор дөрөвт шалгарчээ. Тус улс ЕХ-ны улсуудтай чөлөөтэй зорчих гэрээгээ цуцалж байгаа боловч гадаадаас авьяастнуудыг татах бодлогоо үргэлжлүүлэхээр төлөвлөж буй. Ерөнхий сайд Тереза Мэй мэргэжилтэй цагаачдыг өндөр цалинтай ажилд авахад илүү анхаарна гэжээ.

Хойд Солонгосын удирдагч Бээжинд



Ноён Ким Жон Ун АНУ-ын Ерөнхийлөгчтэй хийж магадгүй хоёр дахь уулзалтын өмнө Хятадын Ерөнхийлөгчтэй зөвлөлдөхөөр Бээжинд дөрөв дэх удаагаа ирсэн бололтой.

Хятад ба Хойд Солонгосын хэвлэлд мэдээлснээр пүрэв гараг хүртэл үргэлжлэх ноён Кимийн айлчлалд эхнэр Ри Сол Жу дагалдан явж байна. Мягмар гарагт Хойд Солонгосын удирдагчийн 35 насны ой тохиож байгааг Өмнөд Солонгосын Нэгдлийн яам мэдээлэв.

Хоёр тал Пхеньяны цөмийн хөтөлбөрийн талаар голлон ярилцах ба АНУ-тай хэлэлцээ хийхэд Шигээс дэмжлэг хүсэх байх гэж ажиглагчид тэмдэглэжээ.

Хятадын 2019 оны шилдэг хувьцаа 34 хувь өслөө



Founder Securities компанийн хувьцаа 2018 дуустал дөрвөн жил дараалан уруудсан. Гэхдээ он гарангуут байдал өөрчлөгдөж, Хятадын томоохон 300 хувьцааны жагсаалтыг тэргүүлэв. Бээжинд байрладаг тус компанийн хувьцаа өнгөрсөн онд 24 хувиа алдсан бол 2019 онд 34 хувь өссөн байна. Гэвч хувьцааны хөдөлгөөнийг тайлбарладаг шинжээчид уг өсөлтийг юу түлхсэнийг хэлж магадгүй байгаа аж. Шанхайн фирмийн шинжээч Лиоо Ченкай "Founder суурь үзүүлэлтүүд бусдаас онцгой зүйлгүй" гэжээ. Тус компанийн гол багцыг эзэмшигч Бээжингийн их сургуулийн харьяа Founder Group нэгдэл буюу худалдан авалт гэх мэт заавал ил болгох ёстой томоохон үйл ажиллагаа төлөвлөгдөөгүй байгаа хэмээн мэдэгдэв.

Эдийн засаг

Дэлхийн худалдааны харилцаа хямарч, ам.долларын ханш өссөний улмаас зэсээс цайр хүртэлх төмөрлөгийн үнэ 2018 онд суларсан юм.



Хятадаас үүдэн Goldman Sachs үнийн таамгаа бууруулав

Өнгөрсөн 2018 онд дөрвөн хувьтай байсан дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалт энэ жил 10 хувь болж хурдсах тул дотоодын нийт бүтээгдэхүүний улирлын өсөлт ч дээшилнэ

Хэмээн шинжээчид таамаглав. Дэлхийн худалдааны харилцаа хямарч, ам.долларын ханш өссөний улмаас зэсээс цайр хүртэлх төмөрлөгийн үнэ 2018 онд суларсан юм. Хятадад эрэлт буурснаас голлон шалтгаалж

үйлдвэрлэлийн албан ёсны индекс ч 2016 оноос хойш энэ 12 дугаар сард анх удаа бууралтын бүсэд гулсан орлоо. Азийн гол эдийн засгийн эрэлт "суларсан нь эргэлзээгүй боллоо" хэмээн Goldman тайлбарлаж байна.

	3 сарынх	6 сарынх	12-сарынх
Зэс	\$6,100 (\$6,500)	\$6,400 (\$7,000)	\$7,000 (Өөрчлөлтгүй)
Хөнгөн цагаан	\$1,900 (\$2,100)	\$1,950 (\$2,000)	\$2,000 (Өөрчлөлтгүй)
Цайр	\$2,500 (\$3,300)	\$2,400 (\$3,000)	\$2,200 (\$2,800)
Никель	\$11,000 (\$15,000)	\$11,500 (\$16,000)	\$12,500 (\$18,000)

“Энэ оны эхний улиралд металлын үнэ хүндхэн байх төлөвтэй”-г шинжээчид анхааруулж байна. “Өмнө нь 2015-2016 онд тохиолдсон сургамжаас үзвэл хөрөнгө оруулагч нар урт позиц баримтлахаасаа өмнө эрэлт сайжрах төлөвтэй эсэхийг баттай мэдэж авахаар хичээж буй бололтой”. Goldman оны сүүлийн хагаст зэс зэрэг зарим металлын эрэлт ихсэж Хятадын зах зээлд микро өсөлт үүсэж хэмээн өөдрөг тооцоолж байсан юм. Хэдийгээр металлын үнийн төлөвийг бууруулж өөрчилсөн ч “зах зээлийн суурь сайн хэвээр” хэмээн тус групп үзлээ. Хятадын төв банк зээлдүүлэгчдийн нөөцөд тавьдаг хязгаарлалтаа баасан гарагт дахин сулруулсны дүнд билгийн тооллын сар шинийн баяраас өмнөх санхүүжилтийн хомсдолыг арилгах 800 тэрбум юань (117 тэрбум ам.доллар) эргэлтэд орж байна. Тус улсын эрх баригчид татвар хөнгөлөх, санхүүгийн зардлыг өсгөх зэрэг өсөлт дэмжих бусад арга хэмжээ ч авна хэмээн UBS Group AG таамаглаж байна. Индонезийн хямд зардалтай нийлүүлэлт ихэссэнтэй уялдан цайрын үнийн таамгаа Goldman эрс буурууллаа. Goldman Sachs 12 сарын дотор нийлүүлэх никелийн нэг тонныг нь 18 мянган ам.доллараар тооцоолж байснаа 12,500 болгон өөрчилжээ.



Эм үйлдвэрлэлийн салбарыг өөрчлөгч 62 тэрбумын хэлцэл

Лайза Ду Takeda Pharmaceutical 62 тэрбум ам.доллараар Shire компанийг өөртөө нэгтгэх ажиллагаа мягмар гарагт дууссан. Ингэснээр хурдацтай хувирч буй эм үйлдвэрлэлийн салбарт дахин нэг том өөрчлөлт бий болов. Takeda-гийн хэлцэл нь 2018 оны дэлхийн хамгийн том худалдан авах ажиллагаа болсон. Хэлцлийн дүнд 237 жилийн түүхт япон компани ховор өвчнийг эмчлэх эмчилгээ, АНУ-ын зах зээлд эзлэх байр суурь бүхий дэлхийн шилдэг 10 эм үйлдвэрлэгчийн нэг болж хувирлаа.



чадлаа. Тоо нь цөөрч буй хүн амаасаа шалтгаалаад өсөлтийн найдвартай үүсвэр болж чадахгүй байгаа Японд эмийнх нь үнэ жил дараалан буурч ирлээ. АНУ-д эмийн үнэ мөн адил эрсдэлтэй ч гэлээ орлогын тогтвортой үүсвэр хэвээр. Аварга хэлцлийн хөөрөлд татагдсан Takeda өөрөө ч зээлийн хүнд ачаатай. Тус компани санхүүгийн хөшүүргээ багасгах кампанийн хүрээнд 10 тэрбумын дивестмент буюу хөрөнгө оруулалтаа эргүүлэн зарах хувилбар боловсруулж байна. Энэ онд зарим активаа зарах гэж байгаа Takeda-гийн гүйцэтгэх захирал Кристоф Вебер даваа гарагт хөрөнгө оруулагчдадаа мэдэгдлээ. Тус компани бизнесийн ач холбогдол багатай, Японоос гадна байрладаг салбаруудаа зарах арга эрэлхийлж байна. Takeda-гийн зээлийн дарамт нь аварга бизнес хэлцлийг өөнтөлөгчдийн шүүмжлэлийн гол байсан төдийгүй Moody's Investors Service тус компанийн


зээлжих зэрэглэлийг бууруулах шалтгаан болсон юм. Shire-ийг нэгтгэхийн тулд өрөн дээрээ нэмж 30 тэрбум ам.доллар зээлсэн хэлцлийн дүнд Take-da-гийн цэвэр зээлийн хэмжээ орлогоос нь тав дахин хэтэрлээ. Хэлцлээс өмнө тус компанийн цэвэр зээл орлогоос нь хоёр дахин их байжээ. Shire-ийг худалдан авах сонирхолтойгоо анх мэдэгдсэн 2018 оны гуравдугаар сараас хойш Takeda-гийн хувьцааны үнэ 26 хувиар уналаа. Үнийн санал тавьсан тавдугаар сард Shire-ийн зах зээлийн үнэлгээ Take-da-гийнхаас илүү байсан юм. Хэлцэл амжилттай дууссаныг Takeda мэдэгдэж, SMBC Nikko Securities зээлжих зэрэглэлийг нь өсгөсний дараа Токиод мягмар гарагийн арилжаагаар тус үйлдвэрлэгчийн хувьцааны үнэ 2.9 хувиар өсөв. Өмнө нь буюу даваа гарагт Takeda-гийн хувьцааны үнэ 7.5 хувиар сайжирсан нь сүүлийн гурван жилийн үнэмлэхүй өсөлт болсон юм.

Дэлхийн Банкны ерөнхийлөгч гэнэт огцорлоо

Эндрю Майеда Дэлхийн Банкны тэргүүн Жим Ён Ким хугацаа нь дуусахаас гурван жил гаруйн өмнө албан тушаалаасаа гэнэт огцорлоо. Хөгжлийн зээлдүүлэгчийн зорилго нь юу болохыг нухацтай асуугч Трампын засаг захиргааны асуулттай уялдан уг байгууллагын шинэ тэргүүн хэн байх талаар олон улсын маргаан дэгдэх төлөвтэй.

дахь таван жилийн хугацаат алба нь 2017 оны долдугаар сараас эхэлжээ. Дэлхийн Банкны нөөцөд оруулдаг хувиа АНУ хязгаарласны дараа, өнгөрсөн оны дөрөвдүгээр сард тэрбээр гишүүн улсуудаас 13 тэрбум ам.долларын хөрөнгө нэмж төвлөрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Барак Обама сонгосон Кимийн оронд Ерөнхийлөгч Дональд Трамп өөрт нь илүү тохирсон

дууссан санхүүгийн жилд Дэлхийн Банк бараг 64 их наяд ам.долларыг хөгжиж буй улсад зээл болгон олгосон юм. Хөгжлийн зээлдүүлэгч Дэлхийн Банкны гол хувьцаа эзэмшигч нь АНУ. Дэлхийн II дайны дараа буюу 1945 онд Европыг сэргээн босгох ажлыг санхүүжүүлэх зорилгоор тус банкныг байгуулсан түүхтэй. Байгуулагдсан цагаасаа хойш




“Удирдлагад дээрээсээ хоёрдугаарт ордог Кристилина Георгиева хоёрдугаар сарын нэгнээс түр ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэнэ” хэмээн Вашингтонд төвтэй тус банк даваа гарагт мэдэгдэв. Хөгжиж буй орнуудад дэд бүтцийн хөрөнгө оруулалт эрхэлдэг хувийн компанид ажиллах гэж буйгаа ноён Ким банкны ажилтнуудад илгээсэн цахим захидалдаа тайлбарлажээ. “Хувийн секторт ажиллах боломж гарсан нь гэнэтийн зүйл. Энэ замаар замнаж байж л уур амьсгалын өөрчлөлт, хөгжиж буй улсууд дахь дэд бүтцийн дутагдал зэрэг дэлхийн цар хүрээтэй бэрхшээлийг шийдвэрлэхэд илүү хувь нэмэр оруулж чадах юм байна гэсэн дүгнэлт хийлээ” хэмээн ноён Ким мэдэгдэв. Эдүгээ 59 настай ноён Ким тус банкны тэргүүний албыг улиран хашиж байсан юм. Хоёр

америк хүнийг Дэлхийн Банкны тэргүүнээр дэвшүүлэх бололтой. Шинэ нэр дэвшигч нь Трампын адилаар Дэлхийн Худалдааны Байгууллага, НАТО зэрэг олон улсын институтыг адлагч байх аваас тус банкинд хүндрэлтэй. Трампын аюулгүй байдлын зөвлөх Жон Болтон 2016 онд бичсэн шүүмжлэлд Дэлхийн Банкныг хувьчлах учир шалтгааныг дурдаж байв. Дэлхийн санхүүгийн зах зээлд хэдийн нэвтэрсэн БНХАУ-д тус банк яагаад ийм их мөнгө зээлдүүлээд байгаагийн учрыг АНУ-ын Сангийн Яамны дэд сайд Дэвид Мальпас асууж байв. Худалдааны зөрчил, өссөөр байгаа АНУ-ын бодлогын хүү хөгжиж буй зах зээлд дарамт учруулж байгаа нөхцөлд тус банк капиталдаа хэрхэн зарцуулах нь Трампын шийдвэрээс хамаарч болзошгүй. Өнгөрсөн оны зургадугаар сарын 30-наас

даян дэлхийд хэт ядуурлыг бууруулахад хүчин зүтгэж ирсэн тус банкныг байнга америк хүн удирдаж ирсэн юм. Дэлхийн Банктай төрөл нэгтэй Олон Улсын Валютын Санг өрнөдийн гүрнүүдийн хоорондох бичигдээгүй тохиролцоогоор байнга европ хүн удирдаг. Францын Сангийн сайд байсан Кристин Лагард эдүгээ тус байгууллагыг тэргүүлж байна. Трампын засаг захиргаа тус банкинд дайсагнагч байр суурьтай хүнийг тэргүүнээр дэвшүүлэх аваас гишүүн улсуудын эсэргүүцэлтэй тулгарч болзошгүй. Уламжлалаараа Дэлхийн Банкны тэргүүнийг АНУ-ын Ерөнхийлөгч томилдог ч эцсийн зөвшөөрлийг тус байгууллагын удирдах зөвлөл гаргадаг юм. Кимийн залгамжлагчийг сонгох ажил эхэлснийг Дэлхийн Банкны удирдах зөвлөл даваа гарагт мэдэгдлээ.

Эдийн засаг



ЗГМ ТОВЧХОН

» ЭКСПОРТ

36

Сая тонн нүүрс. Монгол Улс 2018 онд 36 сая гаруй тонн нүүрс экспортолсон. Гашуунсухайт-Ганцмод боомтын нүүрсний экспорт өнгөрсөн онд нэг сая тонноор нэмэгдэж, 18.2 сая тоннд хүрсэн. Харин Шивээхүрэн-Сэхэ боомтын экспорт 1.4 сая тонноор нэмэгдэж, 14.1 сая тонн болжээ. Мөн Замын-Үүд-Эрээний боомтоор төмөр замаар дамжуулан 1.8 сая тонн нүүрс экспортолсон нь 2017 оныхоос 450 мянган тонноор нэмэгдсэн дүн.

» ТААМАГ

Eurasia групп 2019 онд олон улсад тулгарах хамгийн гол эрсдэлээр геополитикийн зөрчлийг нэрлэсэн байна. Үүнд, худалдааны маргаан, АНУ-ын улс төрийн дотоод зөрчил, цахим халдлага зэрэг багтжээ.

ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн ухаалаг телевизорын зах зээлийн 33 хувийг Samsung компани эзэлдэг.

ВАЛЮТЫН ХАНШ

Валюту	Ханш
АНУ-ын доллар	2,636.78
Евро	2,994.99
Японы иен	23.43
ОХУ-ын рубль	39.52
БНХАУ-ын юань	382.19
БНСУ-ын вон	2.34

Гадныхаас илүү дотоодын хөрөнгө оруулалтад найдах хэрэгтэй

Нэг өрх дунджаар 560 мянган төгрөгийн зээлтэй

М.Дэлгэрмаа, Б.Баярмаа
ЗГМ

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг энэ онд зургаа гаруй хувьд хүрнэ гэж олон улсын байгууллагууд таамаглаж буй. Энэ онд макро эдийн засгийн орчинд тулгарах магадлалтай сорилт, өөрчлөлтийн талаар эдийн засагч Б.Энхбайгальтай ярилцла. Тэрбээр өрхийн зээлийн хэмжээг хязгаарлах нь эрсдэлээс сэргийлсэн зөв алхам гэдгийг тодотгосон юм.

-2018 онд манай улсын эдийн засаг ямар өнгө төрхтэй байв? Та хэрхэн дүгнэж байна вэ?

-Өнгөрсөн оныг сорилтын жил байсан гэж хэлж болно. Дэлхийн зах зээл, олон улсад улс төрийн байдал тогтворгүй байлаа. Мөн дотоодод ч олон сорилт тулгарлаа. Хамгийн гол нь төсвөө нэлээн алдагдалтай баталсан. Үүний үр дагавар нь ирэх жилүүдэд бодитоор мэдрэгдэх байх.

-2019 онд манай улсын эдийн засаг ямар байх бол? Ялангуяа, эхний хагас жилд биднийг ямар өөрчлөлт, сорилт хүлээж байгаа вэ?

-Улсын төсвийг нэлээн өндөр төсөөлж, баталсан учир жилийн эхний хоёр улиралд орлого гүйцэх эсэх нь эргэлзээтэй байна. Хэдийгээр ОУВС-гийн санхүүжилт манай улсад орж ирэх ч гадаад өр нэмж байгаа нь цаашдаа эдийн засагт нэлээн хүнд сорилт болно.

-Удахгүй бизнесийн салбар идэвхждэг улирал ирнэ. Бизнесийн орчин таатай байж чадах болов уу?

-Бизнесийн салбарт хамгийн том эрсдэл нь дотоодын улс төрийн тогтворгүй байдал. Энэ онд ч мөн адил. Өнгөрсөн онд, инфляци савлагаатай байсан. Шатахууны үнэ нэмэгдсэнийг дагаад эрчим хүч, өргөн



хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өслөө. Хэрэв энэ байдал цаашид үргэлжилбэл улсын эдийн засаг нэлээн хүнд байдал орно.

-Үнийн өсөлттэй холбоотойгоор Төв банкнаас хэрэгжүүлсэн бодлогыг хэр үр дүнтэй байсан гэж үзэж байна вэ?

-2018 оны сүүлээр хийсэн интервенц тодорхой хэмжээний үр дүнд хүрсэн. Гэхдээ шатахууны үнэ ханш өндөр, дэлхийн зах зээл дээрх үнэ нь манайхаас хамаарахгүй савлаж байгаа учраас Засгийн газрын шийдэж чадах, чадахгүй асуудал бий л дээ. Гэхдээ л аль болох зохицуулах шаардлагатай. Дахин хэлэхэд монголчуудын өргөн хэрэглэдэг А92 шатахууны үнэ өшөө өсвөл манай эдийн засагт хүндхэн тусгах байх.

-Гадныхн хөрөнгө оруулалт

яаж татах вэ гэж бизнес эрхлэгчид толгойгоо гашилгаж байна. Манайд гадныхн хөрөнгө оруулалт бага хэмжээгээр орж ирж байгаа ч хэт төвлөрсөн. Үүнийг хэрхэн зохицуулах вэ?

-Өнөөдөр дотоодын хөрөнгө оруулалт эдийн засгийг хөдөлгөж байна гэж харж болохоор байна. Энэ онд гадныхн хөрөнгө оруулалт огцом нэмэгдэнэ гэж хүлээх хэрэггүй байх. Дэлхийн эдийн засаг нэлээн саарах, тогтуун хэмнэлттэй байх төлөвтэй. Ирэх онд дэлхийн эдийн засгийн өсөлт 2.2 хувьтай байна гэж олон улсын шинжээчид таамагласан. БНХАУ болон хөгжиж байгаа эдийн засгууд нэлээн өсөх байх. Харин Европ тивийн орнууд, АНУ-ын өсөлт тааруу байх шинжтэй. Тиймээс аль болох дотоодын үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид, хөрөнгө

орлуулагчдаа дэмжих нь чухал. Чамлахаар чанга атга гэгчээр дотоодын хөрөнгө оруулалтыг дутуу үнэлэх хэрэггүй. Харин Засгийн газар батлахгүй удаан хүлээгдэж буй татварын тухай багц хуулийг баталж, бизнесийн орчныг илүү тодорхой, ойлгомжтой болгох шаардлага бий. Энэ онд эдийн засаг доторх хуваарилалтаа бодлогын хувьд тэнцвэртэй болгох хэрэгтэй. Хувийн хэвшлийнхэнд хуримтлал бий болгох чадвар их чухал. Одоогийн байдлаар том бизнесүүд л хуримтлал үүсгэж байгаагаас биш жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд боломж алга. Мөн далд эдийн засагт их хэмжээний мөнгө эргэлдэж байгаа талаар мэдээлэл буйг анзаарахгүй өнгөрч болохгүй.

-Өрхийн өр, зээлийн харьцааг илүү хатуу болгосон журмын талаар та ямар байр суурьтай байна вэ?

-Өрхүүдийн зээлийн хэмжээ нэлээн өссөн нь бодит үнэн. Нэг өрх сард дунджаар 560 мянган төгрөгийн үндсэн зээлтэй гэсэн судалгаа гарсан. Үүнд зээлийн хүү болон бусад өр, зээлийг нэмж тооцвол дүн нь багагүй

өснө. Өрх, айл болгон л ямар нэг байдлаар зээлтэй байна шүү дээ. Тэтгэвэр, сургалт, орон сууц, хэрэглээний зээлийн хэмжээ өсөөд байхад нөгөө талд орлого нь үүнтэй жишихүйцээр өсөж чадсангүй. Өрийн хэмжээ энэ байдлаараа нэмэгдээд байвал эдийн засагт асар том эрсдэл үүснэ. Тиймээс хязгаарлах нь зөв. Үүнийг иргэдэд зөвөөр ойлгуулах хэрэгтэй. Улсын эдийн засаг болон тухайн өрхийн санхүүг эрсдэлээс хамгаалж буй шийдвэр шүү дээ. Эрсдэлтэй зээл нэмэгдэж, иргэд эргэн төлөх чадваргүй болчихвол банкны салбарт ч хүндрэл нэмэгдэнэ. Тиймээс тодорхой хэмжээний амьжиргааны хэрэглээг дэмжээд, бусдыг нь хязгаарлах нь зүйтэй.

-Эдийн засагт сорилт тулгарахад нөгөө талд боломж гарч ирдэг. 2019 онд манай улсад ямар зэрэг боломж байна вэ?

-Улсын төсвийг аль болох бага тодоггож, зардал нэмэхгүй байх хэрэгтэй. Мөн төсвөө эхнээс нь л хэмнэлттэй, бодлоготой зарцуулах нь Сангийн яамны анхаарах гол зүйл. Мөн зээлжих зэрэглэлийг бууруулахгүй барьж чадвал олон боломж нээгдэнэ. [ЗГМ]

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2019.01.08

Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь Чингэлтэй дүүргийн хороодын нутаг дэвсгэрт 2019 онд орон нутгийн сангийн хөрөнгөөр камержуулалт хийх ажлын зураг төсөл гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Доорх төслүүдийг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний тендер зарлаж байна. Үүнд :

- 1.1 Чингэлтэй дүүрэг, 2 хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх ажлын зураг төсөл хийлгэх
- 1.2 Чингэлтэй дүүрэг, 5 хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх ажлын зураг төсөл хийлгэх
- 1.3 Чингэлтэй дүүрэг, 7 хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх ажлын зураг төсөл хийлгэх
- 1.4 Чингэлтэй дүүрэг, 8 хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх ажлын зураг төсөл хийлгэх
- 1.5 Чингэлтэй дүүрэг, 9 хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх ажлын зураг төсөл хийлгэх
- 1.6 Чингэлтэй дүүрэг, 11 хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх ажлын зураг төсөл хийлгэх
- 1.7 Чингэлтэй дүүрэг, 13 хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх ажлын зураг төсөл хийлгэх
- 1.8 Чингэлтэй дүүрэг, 14 хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх ажлын зураг төсөл хийлгэх
- 1.9 Чингэлтэй дүүрэг, 15 хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх ажлын зураг төсөл хийлгэх
- 1.10 Чингэлтэй дүүрэг, 16 хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх ажлын зураг төсөл хийлгэх
- 1.11 Чингэлтэй дүүрэг, 17 хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх ажлын зураг төсөл хийлгэх
- 1.12 Чингэлтэй дүүрэг, 18 хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх ажлын зураг төсөл хийлгэх

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (аж ахуйн нэгжийн танилцуулга, ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл, шаардлагатай тусгай зөвшөөрөл) ирүүлнэ. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

Нэмэлт мэдээллийг **2019 оны 01 дүгээр сарын 15-ний өдрийн 12 цаг 00 минут** хүртэл авч болно.

Зөвлөхийн мэдүүлгээ дор дурдсан хаягаар **2019 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 15 цаг 00 минут** дотор ирүүлнэ үү.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, IV хороо Ж.Самбуугийн гудамж-16, Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын II байр, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр Худалдан авах ажиллагааны алба 5 дугаар давхар, 511 тоот Утас : 70110769

ХӨРШ

VI: БНХАУ-д коксжих нүүрсний ханш буурах төлөвтэй

Б.Дашням
Шинжээч

БНХАУ-д энэ онд шинээр эхлэх үл хөдлөх хөрөнгийн бүтээн байгуулалт цөөрснөөр гангийн эрэлт буурах төлөвтэй. Энэ нь гол түүхий эд болох коксжих нүүрсний ханшид ч сөргөөр нөлөөлөхөөр байна. Bloomberg Intelligence-ийн судалгаанд макро хүчин зүйлээс гадна БНХАУ-ын Засгийн газрын төлөвлөгөөний хэрэгжилт тааруу байгаа нь гангийн эрэлтийг бууруулж буйг дурджээ.

Тухайлбал, шинэ барилга босгох зорилгоор газар чөлөөлөх ажил удааширсан байна. БНХАУ 2014-2020 онд хотын ядуусын хорооллын барилгыг нурааж, шинэ барилга барихаар тусгажээ. Гэвч орон нутгийн захиргаа газар чөлөөлөх ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж чадахгүй байгаа аж. Түүнчлэн түр нүүлгэн шилжүүлэх шаардлагатай иргэдэд өгөх халамж, барилгын ажилд татаас олгоход их хэмжээний хөрөнгө шаардах

болсон аж. Арилжааны банкнууд энэ чиглэлд зээл олгохоо больсон нь ажил удааших гол шалтгаан болжээ.

Судалгаанд оролцсон шинжээчдийн таамаг энэ онд коксжих нүүрсний эрэлт буурснаар ханш нь зургаа орчим хувиар буурч, 178 ам.доллар хүрэх төлөвтэй. Экспортын хувьд Австралийн нийлүүлэлт энэ онд хамгийн их буюу найман сая тонноор өсөх бол ОХУ-ын экспорт Mechel уурхайн гарц нэмэгдсэнээр гурван сая тонноор өсөхөөр байна. Австралийн коксжих нүүрсний нийлүүлэлт 2021 он гэхэд 29 сая тонноор өсөх бол ОХУ-ын экспорт энэ хугацаанд 5-6 сая тонноор өсөхөөр байна.

Харин Монголын тухайд хилийн нэвтрүүлэх хүчин чадлын хязгаар нүүрсний экспорт өсөхөд тушаа болно гэж Лондон дахь Bloomberg-ийн шинжээчид дүгнэв. Дунд хугацаанд Энэтхэг болон Азийн орнуудын коксжих нүүрсний өсөн нэмэгдэх хэрэгцээний дийлэнхийг ОХУ, Австрали хангахаар байна.

АРИЛЖАА

“Хөвсгөл Алтан дуулга”-ын хувьцааны ханш 22 дахин өсжээ

Монголын хөрөнгийн биржийн II ангилалд бүртгэлтэй “Хөвсгөл Алтан дуулга” компанийн хувьцааны ханш сүүлийн нэг жилийн хугацаанд 22 дахин өсөж, 900 төгрөгт хүрээд байна. Хөвсгөл аймгийн Тариалан суманд газар тариалан эрхэлж, гурил болон тэжээлийн үйлдвэр ажиллуулдаг тус компани 2018 онд нэмж хувьцаа гаргасан юм. Ингэснээр олон нийтээс 3.7 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн.

2018 оноос үйл ажиллагаагаа өргөтгөж, Улаанбаатар хотод бүтээгдэхүүнээ нийлүүлж эхлэсэн бөгөөд энэ нь борлуулалтад нь эерэгээр нөлөөлсөн байна. Тухайлбал, 2018 онд борлуулалт нь жилийн дунджаас 50 гаруй хувиар өсжээ. 2018 оны эцсийн байдлаар “Хөвсгөл Алтан дуулга” компанийн 73.9 хувь дөрвөн том хувьцаа эзэмшигч, 26.1 хувь нь 240 жижиг хувьцаа эзэмшигчийн мэдэлд байна.

Эдийн засаг

Татвар нэмэх суурь орчин огт бүрдээгүй байна

Тиймээс ч хөгжингүй болон амжилттай хөгжиж буй улс орнууд татвар нэмэхдээ болгоомжтой ханддаг.

Тун ойрын жишээ нь Япон улс. Манайхны ойлголтоор бол нэмэгдсэн өртгийн албан татвар буюу худалдааны татвараа тус улс хоёр нэгжээр нэмж, 10 хувь болгохын тулд таван жил бэлтгэж байна. 2017 оны дөрөвдүгээр сард нэмэхээр төлөвлөж байсан ч тухайн үед татвар нэмэх суурь нөхцөл бүрдээгүй хэмээн үзэж, энэ оны аравдугаар сар болгон хойшлуулсан байна.

Тус улсын Засгийн газар эрүүл мэндийн салбарт хийсэн шинэчлэл, насжиж буй хүн амын эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг татварын нэмэгдлээс олохоор тооцсон ч ОУВС болон шинжээчид татвар нэмэх цаг гэдгийг сэрэмжүүлж байна.






Хэдийгээр онцгой албан татварыг эргээд тэглэсэн ч дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өөрчлөлтийн улмаас манайд ч гэсэн жижиглэнгийн үнэ савлагаатай байна. Гэтэл энэ савлагаанд өртсөн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ буурах шинж огт алга.

С.Батсайхан / ЗГМ ©

Манай эрх баригчид татвар нэмэхдээ шаламгай, багасгахдаа хойрго

Тиймээс Шинзо Абэгийн Засгийн газар дөнгөж сэргээд байгаа хэрэгтэй болон иргэдийн автомашин, орон сууцны худалдан авалтад сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх бэлтгэл хангаж буй аж. Тус улс 1972 онд нэмэгдсэн өртгийн албан татвартай болсноос хойш 47 жилийн турш уг татварын хувь хэмжээг долоон хувиар л нэмсэн байна. Ингэхдээ эхний 25 жил буюу эдийн засаг нь хамгийн өндөр өсөлттэй байсан он жилүүдэд тогтмол гурван хувь, 1997-2014 онд таван хувь, 2014 оноос өнөөг хүртэл найман хувиар нэмэгдүүлжээ. Энэ хугацаанд ДНБ нь 318 тэрбум ам.доллараас 5.1 их наяд ам.доллар болж, 16 дахин нэмэгдсэн аж.

Өөрөөр хэлбэл, иргэдийнх нь цалин хөлс, амьжиргаа, худалдан авах чадвар сайжирч, хөрөнгө оруулалт, бизнесийн орчин таатай болж, макро эдийн засаг тогтворжсоны дараа татварын хувь хэмжээгээ нэмсээр иржээ. Эдийн засгийн орчинтой нь харьцуулахад манайд НӨАТ 10 хувь байгаа нь өндөр татвар гэдэг нь ойлгогдож буй биз ээ. Эдийн засгийн суурь орчин сайжирсан нөхцөлд л татвар нэмдэг нь зүй тогтол гэдгийг эдийн засагчид онцолж буй. Тиймээс ч хөгжингүй улс орнууд харьцангуй өндөр, хөгжиж буй нь бага татвартай байдаг аж. Харамсалтай нь манай улс ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд татварын хувь хэмжээг өсгөх нь төсвийн орлогыг нэмэх гол эх үүсвэр гэж харсан. Өөрөөр хэлбэл, хямралтай жилүүдийг үдэж, 2017 онд ёроолоос дөнгөж өндийж байсан эдийн засгаа татвараар дарамталж эхэлсэн нь баялаг бүтээгчид, иргэдийн өсөж өндийх боломжийг боомилсон алхам болсон юм. Үүний балаг одоо ч арилагүй байгаа. Онцгой албан татвар нэмэх сургаар шатахууны үнэ 100 төгрөгөөр нэмэгдэж, улмаар өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өссөн. Хэдийгээр онцгой албан татварыг эргээд тэглэсэн



ч дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өөрчлөлтийн улмаас манайд ч гэсэн жижиглэнгийн үнэ савлагаатай байна. Гэтэл өрхийн амьжиргаанд чухал үүрэг гүйцэтгэдэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ буурах шинж огт алга.

Зах зээлд шилжсэнээс хойшхи хугацаанд өрнөсөн татварын шинэчлэлийг харахад татварын хувь хэмжээ нийтдээ 45-10 хувь болтлоо буусан байдаг. Гэсэн ч энэ нь эмзэг эдийн засагт дөндүү өндөр хэмжээ, томоохон дарамт байсаар ирсэн. Үүний нэг тод илрэл нь 2008 онд баталсан өршөөлийн хуулиар нийтдээ таван тэрбум ам.долларын далд эдийн засаг ил болсон бол 2015 оныхоор 34.5 их наяд төгрөгийн хөрөнгөө

компаниуд мэдүүлсэн түүхтэй.

Өөрөөр хэлбэл, ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд татвар нэмэх шийдвэр гаргасан нь эрх баригчид татварыг зөвхөн төсвийн орлого бүрдүүлэх эх үүсвэр л гэж харж буйн илрэл юм. Түүнээс биш эдийн засгийг зохицуулдаг, бизнесийг тэтгэдэг хүчин зүйл гэдгээр нь огт хараагүй гэдэгтэй маргах хүн байхгүй биз. Үүнийг батлах бас нэг зүйл бол татварын шинэчлэлийн үргэлжлэл болсон гурван хуулийг хэзээ батлах нь мэдэгдэхгүй байна.

Эдийн засгийн бүтэц, жижиг дунд үйлдвэрлэл, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн Татварын ерөнхий хууль, аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогын албан

татварын тухай хуулийг хэрэв 2016 онд НӨАТ-ын хуультай зэрэгцүүлэн баталсан байсан бол өнөөдөр Монгол Улсын эдийн засгийг дэмжих бодит боломж байх байлаа. “Хэрэв энэ гурван хуулийг баталсан бол аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татвар нэг хувь болж буурснаар өнөөдөр хэрэгжиж байгаа нийгмийн даатгалын нэг хувийн татварын нэмэгдэл ажил олгогчид, иргэдэд дарамт болж очихгүй байх байсан” хэмээн МҮХАҮТ-ын ерөнхийлөгч Б.Лхагважав сануулсан юм.

Татварын нэмэгдэл цагаа олсон уу, эдийн засагт ямар нөлөө үзүүлсэн талаар эдийн засагчдын тухайн үеийн болон одоогийн байр суурийг хүргэе. [ЗГМ]

БАЙР СУУРЬ



З.Нарантуяа
УИХ-ын гишүүн

Эрх баригчид иргэдийн амьжиргаанд нөлөөлөх долоон төрлийн татвар нэмсэн нь өнөөдөр сөрөг үр дагавар бий болгож байна. Шатахууны үнэ болоод хомсдол бий болсон нь нийгмийг бүхэлд нь бухимдууллаа. Энэ удаад шатахууны зохиомол хомсдол үүсгэж, үнийг нь нэмсэн. Үндсэн шалтгаан нь онцгой албан татварыг нэмсэнтэй холбоотой. Уг нь эрх баригчдын хэлж байгаа эдийн засгийн өсөлт нь байгаад, шатахууны 41 хоногийн болон валютын дөрвөн тэрбум ам.долларын нөөцтэй байсан бол өнөөдөр ийм нөхцөл байдал үүсэхгүй байсан.



Б.Лхагважав
МҮХАҮТ-ийн ерөнхийлөгч

Татвар бол онцгой эрх эдэлж гаргаж буй улс төрийн шийдвэр юм. Тиймээс энэ талаар сайн мэдэхгүйгээр татварын бодлого явуулж болохгүй. Өмнө нь Монгол Улсад татварын хувь хэмжээ өндөр байсан нь далд эдийн засгийг бий болгосон. Компаниуд тайлангаа худлаа мэдүүлдэг байсан тул манай бүх тоон мэдээлэл худлаа, үүний улмаас Монгол Улс макро орчны загвараа зөв гаргаж чадахгүй байгаа юм. ОУВС-тай тохиролцоонд хүрсэн 2017 оны долдугаар сараас өмнө татварын орлого эхний хагас жилд хэдийн 500 тэрбум төгрөгөөр давж биелсэн байсан шүү дээ.



Ж.Дэлгэрсайхан
СЭЗИС-ийн багш

ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдахдаа татвар нэмсэн нь ерөөсөө эдийн засгийн орчин бүрдээгүй, нийгмийн шинжтэй арга хэмжээ биш учраас зөвхөн төсвийн орлого бүрдүүлэх л зорилготой байсан. Уг нь татвар нэмэгдэх нь зүй ёсны үзэгдэл боловч эдийн засаг, нийгмийн суурь нөхцөл нь тоон мэдээлэл худлаа, үүний хуваарилалтаар дамжин бизнес болон иргэддээ наалдацтай үед л татварыг нэмэх нь зүйтэй юм. Монгол Улсын хувьд татварын орлого ДНБ-ий 25-30 хувьтай тэнцэж байгаа нь хөгжиж буй орнуудтай харьцуулахад татварын ачаалал өндөр байгааг харуулж байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:

